

**С.Чинзориг: Тэтгэвэр тогтоож буй аргачлалыг өөрчлөх ёстой**

Малчдын 10 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй. >2

**Үл мартагдах Жаки**

Киноны хамгийн хэцүү хэсэг нь Жон Кеннедид халддаг үе. >6

**Багийн спорт хөгжихгүй гэдэг үг ард хоцорсон байх**

Тухайн үед 8-10 настай байсан хүүхдүүд одоо том болж, амжилт гаргаад эхэлж байна. >7



NATIONAL NEWS CORP | БҮРЭГДЭХҮҮН КОМПАНИ

ZASAG.CO



МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2016.12.01, ПҮРЭВ ~ №249 (527)

ҮНЭ: 600Т

## ОНЦЛОХ

### УЛС ТӨР

**Элчин сайд Т.Шимизүг нутаг** буцаж буйтай холбогдуулан Ерөнхийлөгч уулзлаа.

### Гишүүн Л.Энх-Амгалан

"Миний компаниуд Хөгжлийн банкнаас зээл аваагүй" гэв.

### АН-ын Гүйцэтгэх зөвлөл

Н.Алтанхуягийн сэжигтнээр татсан асуудлыг хэлэлцжээ.

### Засгийн газар 70 ам метр

байрыг "Түрээсийн орон сууц" хөтөлбөрт хамруулна.

### Инновацийн тухай хуулийн

хэрэгжилт хангалтгүй байгааг эрдэмтэд шүүмжиллээ.

### ЭДИЙН ЗАСАГ

"Mongolia Energy Corporation"-ий 3-9 дүгээр сарын орлого 48 хувиар өссөн байна.

### Аравдугаар сард орон

сууцны борлуулалт өмнөх сарынхаас 30 хувиар буурчээ.

### Ганц мод боомтоор авдаг

экспортын уул уурхайн бүтээгдэхүүний татварыг БНХАУ нэмлээ.

### "Mines and Money 2016"-ын

үеэр Их Британи олборлох салбарт илүү хамтрана гэв.

### "ОРЕС"-ийн орнууд газрын

тосны гарцаа бууруулах талаар Венад хэлэлцэж байна.

### НИЙГЭМ

#### Г.К.Жуковын мэндэлсний

120 жилийн ойг тохиолдуулан хөшөөнд нь цэцэг өргөнө.

#### Согтуу иргэдийг эмнэлэгт

бус, эрүүлжүүлэхэд хүргэх хуулийн төсөл боловсруулжээ.

#### Газар хөдлөлтийн гамшгаас

урьдчилан сэргийлэх зөвлөлийн хуралдаан боллоо.

#### Хөлбөмбөгийн лигийн

медаль хүртсэн багууд 100 сая төгрөгийн шагнал авлаа.

#### Оюутны сургалтын

төлбөрийн зээлийг ирэх даваа гарагаас олгоно.

### ДЭЛХИЙ

Украинд 350 сая ам.долларын цэргийн тусламж үзүүлэхээр АНУ шийдвэрлэв.

#### Хаванад сая орчим хүн

Фидель Кастротой салах ёс гүйцэтгэлээ.

#### Японы Засгийн газар "Ижил

ажилд ижил хөлс олгох" зааварчилгаа гаргана.

#### Өмнөд Солонгос Ерөнхий-

лөгчид итгэл үл үзүүлэх санал хураалт явууллаа.

#### Израйлийн нисэх хүчин

Сирийн армид агаараас цохилт өгөв.

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

2016.12.01



-6° | -17°

БАГАВАТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЖИРЭГЧИЙН МЭДЭЭНИЙГ 8 ДУГААР НУУРГУУС ҮНИШНА УУ.



Бүхэрх хуулиар хамгаалагдана ©

# Худалдаа сэргэх сар айсуй



"Хөлдсөн" худалдааг "гэсгээх" баярын сарууд эхэлж байна. Худалдаа эрчимжсэнээр эдийн засаг дахь мөнгөн урсгалын хэмжээ нэмэгдэж, бизнесийн идэвхжил сэргэх боломжтой. ▶11

Б.Ганбаяр / ЗГМ ©

## НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

### Жижиг, дунд үйлдвэрлэл дэх сорилт

Б.Баяртогтох @bayartogtokhZGM

Эдийн засгийн хүндрэл удаан хугацааны турш үргэлжилж байгаа нь иргэдийн худалдан авах чадвар муудахад нөлөөлөх болов. Хэрэглээ хумигдаж, нийт эрэлт буурч байгаа нь аж

ахуйн нэгжүүдийн хувьд бараа, бүтээгдэхүүнээ борлуулах, шинээр бараа, үйлчилгээ нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд сорилт болж байна. Зах зээлийн багтаамж агшсанаар жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд бодит эрсдэл учирдаг. Энэ утгаараа хямралын "сүүдэр"-т өртөж байгаа эмзэг хэсэг жижиг,

дунд үйлдвэрлэл эрхлэгч болж байна. Тэдний дийлэнх нь эдийн засгийн хүндрэлийг даван туулах санхүүгийн хуримтлал бүрдүүлж амжаагүй байдаг. Мөн зах зээлд хөлөө олох гэж яваа учраас байр сууриа хангалттай хэмжээнд бэхжүүлж чаддаггүй.

▶3

## БОЛОВСРОЛ

### Хүүхэд, залуусын яриа орчуулгын маягтай болжээ

*Сэтгэлгээний соёлын түвшинд хэлний бодлогыг зохицуулах ёстой*

З.Цэлмэг @tselmegZGM

СЭЗИС-ийн Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн багш, хэл бичгийн ухааны доктор С.Норжинлхамтай монгол хэлний болон орчуулгын алдааны тухай ярилцлаа.

-Та ЕБС-ийн сурагчдад зориулсан монгол хэлний толь бичиг зохиох ажилд гар бие оролцсон хүн. Төрөлх хэлнийхээ толь бичгийг дунд сургуульд хэрэглэх зайлшгүй шаардлага байгаа гэж үү? -Алдаагүй, зөв бичихийн

тулд толь бичиг хэрэглэж сурах хэрэгтэй. Бусад оронд толь бичиг хэрэглэхийг багаасаа сурдаг тул буруу найруулга Харин манайд толь бичиг бол гадаад хэл сурахад зориулсан эд гэж ойлгодог. Үүний уршгаар шинжлэх ухааны найруулга зүй үзэх ёстой их сургуульд үсгийн дүрэм заагаад сууж байна шүү дээ. Энэ бол асар том хоцрогдол. Би оюутнуудад төрөлх хэлнийхээ толь бичгийг байнга хэрэглэхийг зөвлөдөг. Үр дүнд нь оюутнууд зөв бичгийн дүрэм биш дүйцүүлэх орчуулга асуудаг болж байна.

-Төрөлх хэлээрээ буруу ярьж, алдаатай бичиж байгаагийн шалтгаан юу вэ?

-Хүний дотоод бодол санаа хоёр янзын хэлбэрээр гадагшилдаг нь хэл яриа ба тэмдэгт үсэг.

▶4



### Эдийн засгийн өсөлт-шинэ Ерөнхийлөгчийн ирээдүй

Адам Самсон, Жессика Дайе

АНУ-ын эдийн засаг тооцоолж байснаас илүү гуравдугаар улиралд анх удаа өслөө. Орон сууцны үнийн суурь үзүүлэлт ч хямралаас өмнөх үеийн оргил үзүүлэлтийг ардаа орхисон нь Дональд Трампд гэрэлт эдийн засаг өв болон үлдэхийн дохио болов.

АНУ-ын Худалдааны яамнаас гаргасан дотоодын нийт бүтээгдэхүүний тайлангаас үзвэл дэлхийн гол хөгжингүй эдийн засаг гуравдугаар улиралд жилийн өмнөх үеэс 3.2 хувиар

өсчээ. Гэтэл анхны таамаг 2.9 хувь байсан төдийгүй Уолл Стрийг ч эдийн засаг гурван хувиар өснө хэмээн тооцоолж байсан юм. АНУ-ын эдийн засаг энэ гуравдугаар улиралд сүүлийн хоёр жилд байгаагүй хурдацтай өссөнийг мягмар гарагт нийтлэгдсэн дээрх тайлан баталж өглөө. Тус улсын эдийн засаг энэ оны эхний хоёр улиралд 0.8 болон 1.4 хувиар тус тус өссөн юм.

▶9

## ЗГМ: ИНФОГРАФИК



## MSE ALL

789.47  
0.54%

## АЛТ

1187.30  
0.05%

## ЗЭС

5705  
2.9%

## 10-ЧИНГИС БОНД

87.640  
0.06%

## 5-ЧИНГИС БОНД

95.930  
0.09%

## АМ.ДОЛЛАР

2466.64

## ЮАНЬ

358.22

## РУБЛЬ

37.74



## Улс төр

ЗГМ:ТОДРУУЛГА

# С.Чинзориг: Тэтгэвэр тогтоож буй аргачлалыг өөрчлөх ёстой

**Малчдын 10 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй**

**Б.Тогтох**  
ЗГМ

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2030 он хүртэл баримтлах бодлогыг өнгөрсөн баталсан. Энэхүү бичиг баримтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа, аргачлал, тооцооллыг Дэлхийн банк Засгийн газартай хамтран хийж буй юм. Дэлхийн банкны төлөөлөл Монгол Улсад ажиллахдаа тэтгэврийн шинэчлэлтэй холбоотой асуудлаар УИХ-ын гишүүн С.Чинзоригтой уулзаж, байр суурийг нь сонирхсон байна. Энэ талаар УИХ-ын гишүүн С.Чинзоригоос тодрууллаа.

**“Дэлхийн банкны төлөөлөлтэй хийсэн уулзалтаар ямар асуудлыг хэлэлцсэн бэ. Тодорхой шийдэл хүрсэн үү?”**

“Дэлхийн банкны ахлах эдийн засагч Марк Долфмэнтэй уулзаж, тэтгэврийн шинэчлэлийн асуудлаар санал солилцсон. Дэлхийн банкнаас энэ чиглэлд хийж буй судалгааны ажлынхаа талаар танилцуулахдаа юуны өмнө Нийгмийн даатгалын сангийн алдагдлын хэмжээг бууруулах шаардлагатай дуулгасан. Алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувь хүргэхийн тулд тодорхой шалгууруудыг өөрчлөх ёстой гэж үзэж байгаа юм билээ. Тухайлбал, тэтгэврийн насыг нэмэх хэрэгтэй гэсэн саналыг гаргасан байна. Гэхдээ миний хувьд монгол хүний дундаж наслалт харьцангуй өндөр биш тул тэтгэврийн насыг нэмэх нь боломжтой хувилбар биш гэсэн байр суурийг илэрхийлсэн. Мөн



Б.Ганбаяр / ЗГМ

эдийн засгийн хямралтай байгаа өнөө үед тэтгэвэрт гарах насыг өөрчлөх асуудалд болгоомжтой хандах ёстой гэж үздэгээ ч хэлсэн. Үүнээс өөр аргаар Нийгмийн даатгалын сангийн алдагдлыг бууруулах арга зам, хувилбарыг тодорхойлох хэрэгтэй байгаа юм.

**“Нийгмийн даатгалын сангийн алдагдлыг бууруулах өөр ямар арга байгаа вэ?”**

“Тэтгэвэрт гарах насыг

нэмэхээс гадна гурван арга байгаа. Нэгдүгээрт, нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийн хамрах хүрээг нэмэх ёстой. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 1.1 сая иргэн ажил хэргээр эрхэлж байна. Үүний 47.2 хувийг малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид эзэлдэг. Гэтэл малчдын 10, хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 15 хувь нь нийгмийн даатгалд шимтгэл төлж байна.

Өөрөөр хэлбэл, малчид болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 85-90 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй. Энэ хэмжээгээр эдгээр иргэдийн нийгмийн даатгалаас тэтгэвэр авах эрх үүсэхгүй нэг үгээр нийгмийн баталгаа алдагдах сөрөг үр дагавартай юм. Тиймээс нийгмийн даатгалын шимтгэл төлөгчгүй байгаа иргэдийг хамруулах нөхцөл боломжийг эрэлхийлэх хэрэгтэй.

## Алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувьд хүргэнэ

Хоёрдугаарт, Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг арвижуулах санхүүгийн менежментийг сайжруулах ёстой. Өнөөгийн хуулиар НДС-гийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд байршуулах, Засгийн газрын бонд худалдаж авах гэсэн хязгаарлагдмал нөхцөлтэй. Түүнээс гадна тэтгэвэр тогтоож буй аргачлалыг өөрчлөх нь Нийгмийн даатгалын сангийн алдагдал буурахад гол нөлөө үзүүлнэ гэж би үздэг. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж буй хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийг ажилтан 10, ажил олгогч 10 хувиар, сайн дураараа төлж буй иргэд 10 хувиар тооцож төлдөг. Шимтгэл төлсөн иргэд тэтгэвэрт гарахдаа үндсэн цалин хөлснийхөө 45-80 хувиар тогтоосон тэтгэврийг авдаг аргачлалыг нь өөрчлөх шаардлага байгаа юм.

Гуравдугаарт, байгалийн баялгаас орж буй хөрөнгийн тодорхой хувийг Нийгмийн даатгалын санд хуримтлуулах замаар алдагдлыг бууруулах боломж бий. Энэ саналуудаа

би Дэлхийн банкныханд хэлсэн.

**“Ер нь тэтгэврийн шинэчлэл хийх цаг нь мөн үү. Эдийн засгийн хямралтай байгаа үед хэр оновчтой алхам бэ?”**

“Тэтгэврийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлага байгаа. Тэгээд ч одоо бол төрөлт, өсөлт болон дундаж наслалтыг харахад хүн амын идэвхтэй цонх үе нээгдсэн цаг хугацааны хувьд оновчтой үе тохиогоод байна. Үүнээс хойш бол хүн амын дунд ахмадуудын эзлэх хувь өсөх хандлагатай тул тэтгэврийн шинэчлэл хийх хэрэгтэй. Шинэчлэл хийнэ гэхээр 2016, 2017 оноор төсөөлж болохгүй. Магадгүй эдийн засгийн нөхцөл байдал сэргэсэн буюу 2018, 2019 онд хийх боломжтой. Харин энэ хугацаанаас хойшлуулж болохгүй.

**“Дэлхийн банкнаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр томоохон төсөл хэрэгжүүлэхээр болсон гэсэн. Төслийн хүрээнд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ?”**

“Би Хөдөлмөрийн сайдаар ажиллаж байхдаа хөдөөгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд хамтарч ажиллах саналыг Дэлхийн банкинд тавьсан юм. Энэхүү санал өнөөдөр л бодит ажил хэрэг болохоор боллоо. Уг төслийн хэрэгжүүлэхэд Дэлхийн банк 25 сая ам.долларын санхүүжилт хийхээр шийдвэрлэсэн байна. Төслийн хүрээнд гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Нэгдүгээрт, орон нутгийн зах зээл дээр эрэлттэй мэргэжлээр залуучуудыг сургаж, чадавхжуулна. Хоёрдугаарт, өөрөө өөртөө ажлын байр бий болгож байгаа залуучуудыг дэмжиж, бичил зээл олгоно. Ингэхдээ барьцаа хөрөнгө шаардахгүй. Мөн хэрэгтэй тоног төхөөрөмжийг нь урт хугацаатай зээлээр олгохоор төлөвлөсөн байна. Иймд Засгийн газар төслийн амжилттай хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллах л үлдээд байна. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗАР

## Түрээсийн орон сууц хөтөлбөрт өөрчлөлт орууллаа

Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд 50 ам метр талбайтай орон сууцыг төрийн өмчийн орон сууцны санд шилжүүлж байсныг 70 ам метр хүртэл хэмээн өөрчлөхөөр Засгийн газрын хуралдаанаас шийдвэрлэлээ. Ипотекний урьдчилгаа 30 хувийг бэлнээр төлж, банкны зээлийн шалгуур хангах иргэдийн тоо багасаж байгаагаас ТОСК-ийн захиалгаар орон нутагт барьсан 70 ам метр хүртэл талбайтай орон сууцуд борлодоггүй байгаа аж. Иймээс эдгээр орон сууцыг түрээсийн орон сууцны санд шилжүүлэх хүсэлтэй аймгийн Засаг дарга нар Засгийн газарт ирүүлсэн байна. Үүнийг үндэслэн ТОСК-ийн захиалгаар Улаанбаатар хот болон Дархан-Уул, Сэлэнгэ,

Ховд, Увс, Хэнтийд барьсан 70 ам метр хүртэл талбайтай 360 айлын орон сууцыг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлжээ.

Дээрх 360 айлын орон сууцны барилгыг барихад зарцуулсан зээлийн төлбөрт шаардагдах 30 тэрбум 286 сая төгрөгийг хянаж тодотгон улсын төсөвт үе шаттай тусгаж байхыг холбогдох сайд нарт даалгав. Зээлийн төлбөрөө бүрэн төлж барагдуулах хүртэлх хугацаанд зээлийн хүүгийн төлбөрийг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэн 360 айлын орон сууцны түрээсийн төлбөрөөс бүрдүүлэхээр боллоо. Одоогоор 1000 гаруй өрхийг төрийн өмчийн түрээсийн орон сууцанд хамруулах боломжтой байгаа

нь хүсэлт гаргасан иргэдийн 37 орчим хувь юм.

Мөн Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэхээр болов. Уг хуулийг 1994 онд баталснаас хойш Улаанбаатар хот өргөжин хөгжиж, эерэг, сөрөг олон асуудал шинээр гарахын хэрээр хууль цаг үетэйгээ нийцэхгүй болж байгаа учир шинэчлэх шаардлагатай болжээ. Манай улсын нийт хүн амын 46 хувь нь байнга оршин сууж, ДНБ-ий 64.5 хувийг үйлдвэрлэж, улсын хэмжээнд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн 68 хувь нь нийслэлд төвлөрсөн гэсэн статистик мэдээлэл байдаг.

Хууль баталснаар Улаанбаатар хот тогтвортой үзэл баримтлал бүхий эрүүд, аюулгүй

орчинтой, олон төвт суурьшлын тогтолцоонд суурилсан, олон улсад өрсөлдөх чадвартай томоохон төв болох эрх зүйн орчин бүрдэх юм.

Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг 300 гаруй мянган хүн амтай болсон нь 2-3 аймгийн хүн амыг нийлүүлсэнтэй тэнцэж байгаа. Гэтэл дүүрэг учир сумтай адил статустай байдлыг өөрчилж аймагтай ижил статустай болгох юм байна. Ингэснээр төрийн үйлчилгээ 2000 хүнтэй сумын шиг биш аймагаас авдаг үйлчилгээтэй ижил түвшинд хүрнэ гэсэн үг юм.

Төвлөрлийг сааруулах чиглэлээр багагүй зүйл хийхээр төсөлд тусгасан байна. Тухайлбал нийслэлийн дагуул хотод

шилжин байнгын үйл ажиллагаа явуулах, бүртгэлтэй аж ахуйн нэгжид ногдох орлогын албан татварыг 10 жилийн хугацаанд 40 хувь, нийслэлийн дэд төвүүдэд бол татварыг таван жилийн хугацаанд 40 хувиар хөнгөлөхөөр тусгажээ. Мөн дагуул хотод шинээр барьж ашиглалтад оруулсан барилгыг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас 15 жил, дэд төвүүдэд бол 10 жил татвараас чөлөөлөх боломж бүрдэх юм.

Хууль баталснаар нийслэл хот үнэт цаас гаргах, газрын бирж ажиллуулах, Засаг дарга газар өмчлүүлэх, ашиглуулах, эзэмшүүлэх, барилга барих зөвшөөрөл олгохдоо ИТХ-ын саналыг заавал авч байх зэргийг тусгасан байна. [ЗГМ]

БАЙНГЫН ХОРОО

## МҮОНРТ-д мэргэжлийн байгууллагын шалгалт оруулна

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар МҮОНРТ-д хийсэн шалгалтын дүн болон Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцлээ. Хуралдааны эхэнд Х.Чилаажавыг Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжсэн. Х.Чилаажав нь МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүн, даргаар өмнө нь ажиллаж байсан бөгөөд түүнийг “Компанийн сайн засаглалыг дэмжих нийгэмлэг” төрийн бус байгууллагаас дахин нэр дэвшүүлжээ.

Харин Үндэсний зөвлөлийн

гишүүн А.Мөнхбатыг эргүүлэн татлаа. А.Мөнхбат нь 2015 оны дөрөвдүгээр сараас эхлэн өнөөдрийг хүртэл 15 сарын хугацаанд Үндэсний зөвлөлийн хуралдаанд биелчлэн оролцоогүй тул түүнийг эргүүлэн татахаар МҮОНРТ-ийн Хяналтын зөвлөлөөс зөвлөмж гаргасан байна.

Дараа нь Ажлын хэсгийн ахлагч Н.Цэрэнбат МҮОНРТ-д хийсэн шалтгалтын дүнг танилцуулав. Шалгалтаар хөдөлмөр, эрүүд ахуй, санхүү, татварын зөрчил нэлээд илэрснийг тэрбээр дурдсан.

Хэлэлцүүлгийн явцад мэргэж-

лийн байгууллагын шалгалт оруулахыг олонхын саналаар дэмжсэн. Тодруулбал, МХЕГ, Үндэсний аудитын газар, Сангийн яаманд чиглэл өгч, танилцуулахыг үүрэг болгов. Уг асуудлыг хэлэлцэх үеэр УИХ-ын гишүүд байр сууриа илэрхийлсэн юм. Тухайлбал, УИХ-ын гишүүн Н.Энхболд жилийн хугацаанд таван удаа бүтцийн өөрчлөлт хийсэнд шүүмжлэлтэй хандав.

Харин УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат МҮОНРТ-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой гэлээ. Тэрбээр “Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж

өгөх хүсэлтийг МҮОНРТ-ийн уран бүтээлчид тавьсан” гэв. Үүнтэй санал нэг байгаагаас УИХ-ын гишүүн М.Оюунчимэг илэрхийлсэн. Тэрбээр “МҮОНРТ-ийг гурван тэрбум төгрөгийн өрөнд тавьсан байна. Энэ нь хуульд зайлшгүй өөрчлөлт оруулах шаардлага” гэв.

Байнгын хорооны дарга Н.Энхболд хуулиар МҮОНРТ нь татвар төлөгчдийн мөнгөөр санхүүжиж, нийтийн эрх ашгийн төлөө ажиллах чиг үүрэгтэй байгууллага. Гэтэл энэ чиг үүрэг зөрчиж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж чадаагүйгээс

байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүрээд байгаагийн улмаас ажиллагсад нь түр хороо байгуулан удаа дараа гомдол, санал хүсэлт ирүүлсэн. Иймээс Үндэсний зөвлөлийг нь УИХ-аас томилох учраас Байнгын хороо энэ асуудлыг анхааралдаа авч хуулийн хэрэгжилттэй танилцаж холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэл өгөх, шаардлагатай аж. Мөн хууль эрх зүйн орчныг нь боловсруулж болгох нь зүйтэй гэж үзсэний үндсэнд дээр Ажлын хэсэг гаргаж ажиллуулсан гэдгийг тодотголоо. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» **ХАМТЫН АЖИЛЛАГАА**  
Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Япон улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Такэноори Шимизүг бүрэн эрхийнхээ хугацааг өндөрлүүлэн эх орондоо буцаж байгааг нь тохиолдуулан хүлээн авч уулзав.

» **ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**  
УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос “Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийн явц, цаашдын зорилго” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг Төрийн ордноо зохион байгууллаа. Хэлэлцүүлгээс Инновацийн хуулийн хэрэгжилтийг шалгах Ажлын хэсгийг байгуулахаар болсон. Мөн Засгийн газарт холбогдох дүрэм, журмуудыг боловсруулах, өмнө гарсан журмын уялдааг сайжруулах талаар чиглэл өгөхөөр тогтлоо.

» **ТОО**

# 105.8

Тэрбум төгрөг. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2013-2015 онд жилд дунджаар 105.8 тэрбум төгрөг орон нутгийн төсөвт төвлөрсөн байна.

» **ЦЭЦ**

Увс аймгийн Засаг даргыг томилсон Ерөнхий сайдын захирамж Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна гэсэн мэдээллийг нэр бүхий иргэн Цэцэд ирүүлсэн байна. Уг мэдээллийн дагуу үүссэн маргааныг хянан үзүүлэх Цэцийн дунд суудлын хуралдаан ирэх сарын 7-нд болно.

» **МЭДЭГДЭЛ**

УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан Хөгжлийн банкнаас гарсан зээлийн 60 хувь нь МАН-ын гишүүдтэй холбоотой аж ахуй нэгж байдаг гэсэн мэдээллийг үгүйсгэв. Тэрбээр “Миний хувьцаа эзэмшдэг компаниуд Хөгжлийн банкнаас нэг ч төгрөгийн зээл аваагүйг хариуцлагатайгаар мэдэгдье. Тиймээс УИХ-ын Халдашгүй байдлын болон Ёс зүйн дэд хороонд хандаж, УИХ-ын гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхээсээ татгалзаж, хууль хяналтын байгууллагад шалгуулахад бэлэн байна” гэсэн хүсэлт гаргажээ.

» **ТОГТООЛ**

Засгийн газраас автобензин, дизелийн түлшинд ногдуулдаг онцгой албан татварын хэмжээг төрөл тус бүрт дахин тонн тутамд 100 мянган төгрөгөөр бууруулах тогтоол баталлаа. Ингэснээр онцгой албан татварын хэмжээг автобензинд тонн тутамд 160 мянган төгрөг, дизелийн түлшинд 180 мянган төгрөг болголоо.

» **ТӨСӨЛ**

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулна. Ингэснээр 16-40 насны залуучууд анх удаа бие даасан хуультай болох юм. Хууль батлагдснаар залуу гэр бүлүүд хөнгөлөлттэй үнээр орон сууц худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ хэмээн үзэж байгаа аж.

ТОДРУУЛГА &amp; ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» **OPED@ZASAG.CO**

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.



## Нийтлэлчийн булан

# Жижиг, дунд үйлдвэрлэл дэх сорилт

**Улсын хэмжээнд 64.3 мянган аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг**

«1 Энэ нь жижиг, дунд үйлдвэрлэгчдэд нийтлэг сул тал. Бизнесийн орлого муудсанаар аж ахуйн нэгжүүд эргэлтийн хөрөнгөөр дутагдах болсон. Энэ нь үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэх, нэг бол зогсоох эсэхээ шийдэхэд хүргэж байна. Тэр тусмаа үйлдвэрлэлээ хэвийн үргэлжлүүлэхэд санхүүжилтийн бэрхшээл хамгийн ихээр тулгарч байгаа аж.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд Засгийн газар болон олон улсын байгууллагуудаас олгож буй хөнгөлөлттэй зээл төдийлэн хүртээмжтэй биш, олдоц нь бага хэвээр байна. Ийм нөхцөлд үйлдвэржилт тэлэх боломж ихээхэн хомс. Үүнийг “Говийн бүсийн өрсөлдөх чадвар”-ын чуулганд оролцсон Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн төлөөлөл хэлж байв. Тухайлбал, Дундговь аймагт жижиг, дунд үйлдвэрийн зээлийн эрэлт, хэрэгцээ их байдаг ч санхүүжилт хүрэлцэхгүй байгааг тус аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ хэлсэн юм.

Жижиг зах зээлтэй, хэрэгцээ нь хязгаартай орон нутагт нэг төрлийн үйлдвэрлэлд хөнгөлөлттэй зээлийг давхардуулж олгох нь эргээд эрсдэл үүсгэж байгааг МҮХАУТ-ын орлогч дарга М.Сарандаваа өгүүлэв. Тэрбээр “Орон нутагт бүтээгдэхүүн, үйлчилгээний давхардал цөөнгүй гарч байгаа. Энэ нь жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих боломжийг хааж байна. Тиймээс орон нутгийн иргэд зах зээлээ нарийн судалж, нэгнээ дуурайхгүй, аль болох бизнесийн ижил төрлийн үйлчилгээ, үйлдвэрлэл явуулахаас татгалзаж, шинийг эрхэлхийлж, нэвтрүүлэх нь чухал” гэв.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд арилжааны банкуудын зээлийн нөхцөл хатуу, шалгуур өндөр байгаа нь санхүүжилтийн орчны гол бэрхшээл болж байгаа аж. Түүнчлэн банкны зээлийн хүү өндөр, хэмжээ бага, олгосон хугацаа нь бизнесийн үйл ажиллагаатай уялдахгүй байгааг Монголбанкны боловсруулсан “Жижиг, дунд үйлдвэр”-ийн түүвэр судалгаанд дурджээ. Энэ нь найдваргүй зээлдэгч болох эрсдэлийг нэмэгдүүлэх, улмаар дахин зээл авахад хүндрэл үүсгэж байгааг хөндсөн байна. Хөгжиж буй улсуудын нэгэн адил манай улсад жижиг, дунд



С.Батсайхан / ЗГМ©

үйлдвэрлэл эрхлэхэд хамгийн их бэрхшээл учруулж байгаа хүчин зүйл нь санхүүжилтийн асуудал. Ялангуяа, барьцаа хөрөнгө, баталгаа байхгүй мөртлөө санхүүжилт хүсэж байгаа иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл нүдний гэм. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс бэлтгэсэн “Аймгуудын өрсөлдөх чадвар”-ын тайланд “Төр, засгийн зүгээс бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, тэр дундаа санхүүжилт болон татварын оновчтой бодлого явуулах шаардлага тулгарч байна” хэмээн тодотгосон байна. Үүнээс гадна төгрөгийн даалд валюттай харьцах ханшийн сулрал үргэлжилж байгаа нь түүхий эд, тоног төхөөрөмжийн зардлыг өсгөх болжээ. Энэ нь бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж эхэлсэн байна.

Макро эдийн засгийн зүгээс жижиг, дунд үйлдвэрлэлд үзүүлж буй нөлөө 2011 оноос хойш тасралтгүй муудсан бөгөөд Монголбанкны судалгаагаар өмнөх жилүүдээс хамгийн муу дүн энэ онд гарчээ. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралт нь хамгийн их бэрхшээл болж байгааг дурдсан. Гадаад валюттай харьцах төгрөгийн ханшийн уналт нь импортын барааны үнийг өсгөх, улмаар аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн өртгийн нэмэгдүүлэх нөлөөтэй юм.

Улсын хэмжээнд 126.5 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас 64.3 мянга нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж. Үүний 84.3 хувийг жижиг, дунд үйлдвэрийн салбарынхан эзэлж байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ утгаараа үе үеийн Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх зорилт болж ирсэн. Гэвч зээлийн үр ашиг орон нутагт харилцан адилгүй байна.

### Жижиг, дунд үйлдвэрлэл нь эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг

Банкны зээлийн хүү макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдан төдийлэн буурахгүй байгаа. Энэ нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүжилтийн орчны зүгээс хүндрэл үүсгэж байгаа аж. Тухайлбал, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид олгож буй банкны зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 18.2 хувьтай байна. Түүнчлэн банкнаас зээл

авахад тодорхой хувийг зээлийн болон үйлчилгээний шимтгэл хураамжийн төлбөрт авдаг нь аж ахуйн нэгжүүдийн хувьд санхүүгийн хүндрэл учруулахад хүргэх талтай.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй зээлийн дундаж хугацаа 25.4 сар буюу хоёр жил гаруй байгаа нь бизнесийн үйл ажиллагаатай бүрэн уялдалгүй, богино хугацаанд зээлээ эргэн төлөхөд ихээхэн хүндрэлтэй байдаг гэж цөөнгүй үйлдвэрлэл эрхлэгч хэлж байв. “Зээлийн барьцаа хөрөнгөгүй, хөрөнгийн үнэлгээ бага, зээлийг шаардлагатай хэмжээнд бүрэн олгодоггүй болон зээлийн батлан даалтад хамрагдах байдал зэрэг нь хүндрэлтэй асуудал хэвээр байна” хэмээн “Жижиг, дунд үйлдвэр”-ийн судалгааны дүгнэлтэд тэмдэглэжээ.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь зардлын үр ашигт байдал чухал гэж үздэг. Бизнес эрхлэгчид үйл ажиллагааны үндсэн бус зардал болох зээлийн хүү болон шимтгэл хураамжийн төлбөр нь зардлын хувьд хамгийн их хүндрэлтэй байгааг хөндөж байна. Тухайлбал, зээлийн хүү болон шимтгэл хураамжийн төлбөр нь нийт зардлын 15 орчим хувь буюу нэлээд өндөр хувийг эзэлдэг.

Шинэ Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх

чиглэлээр хөнгөлөлттэй зээл олгох “Түр журам”-ыг баталсан. Энэхүү журмын хүрээнд 189 иргэн, аж ахуйн нэгж 200 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн төслөө Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ирүүлжээ. Тус яамны Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

» Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээл төдийлэн хүртээмжтэй биш, олдоц нь бага хэвээр байна.

» Манай улсад жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд хамгийн их бэрхшээл учруулж байгаа хүчин зүйл нь санхүүжилтийн асуудал.

» 189 иргэн, аж ахуйн нэгж 200 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн төслөө Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ирүүлжээ.

Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр хөнгөлөлттэй зээл олгох “Түр журам”-ыг баталсан. Энэхүү журмын хүрээнд 189 иргэн, аж ахуйн нэгж 200 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн төслөө Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яаманд ирүүлжээ.

арваннэгдүгээр сарын 11-23-нд төсөл хүлээн авсан байна.

Ж.Эрдэнэбатын тэргүүлж буй Засгийн газар өөрсдийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд ирэх дөрвөн жилийн хугацаанд жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг эрчимжүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Уг зорилтын хүрээнд аймаг болгонд жижиг, дунд үйлдвэр шинээр барихаар төлөвлөж байгаа юм. Энэ нь МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгалаа олсон бодлогын нэг. Орон нутаг дахь ажилгүйдлийг бууруулж, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд уг зорилт чухал үүрэгтэй байх нь дамжиггүй. Гэхдээ эдийн засгийн одоогийн нөхцөлд хэрэгжинэ гэдэг амаргүй.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан 2009 оноос хойш нийт 7083 төсөлд 742.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл хөнгөн үйлдвэрийн салбарын төслүүд дийлэнх хувийг эзэлжээ. Арилжааны банкуудаас авсан мэдээгээр дээрх сангаар дамжуулан олгосон нийт зээлийн эргэн төлөлт 95 хувьтай байна. Энэ нь олзуурхах сайн мэдээ. Харин шинээр зээл хүсэж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн хувьд санхүүжилт авахад шаардлага улам нарийсаж байгаа нь төслөө хэрэгжүүлэх эхний сорилт юм. [ЗГМ]

# MADE IN MONGOLIA

#МОНГОЛДҮЙЛДВЭРЛЭВ

Даваа гараг /2016.12.05/

## 11:00

20:00 Мягмар, Пүрэв гарагуудад

11:00 Лхагва, Баасан гарагуудад

19:00 Бямба гарагт

12:00 Ням гарагт



Дотоодын боловсруулсан сүүний хэрэгцээний тэн хагасыг дангаараа хангаж буй Монголын ууган сүүний үйлдвэр Сүү ХК-ийг энэ дугаараар танилцуулна. 1958 он байгуулагдсан Сүү ХК нь 2500 гаруй малчид, фермерүүдтэй хамтран ажиллаж 400 орчим хүнийг ажлын байраар хангаж байна. Компанийн үнэт зүйлс, 2016 онд хийсэн хөрөнгө оруулалтууд, салбарын өрсөлдөөн болон цаашдын зорилтын талаар гүйцэтгэх захиралтай нь дэлгэрэнгүй ярилцлаа.



## Боловсрол

## Хүүхэд, залуусын яриа орчуулгын маягтай болжээ

**Бид сэтгэлийн хөдлөл, хандлагаа илэрхийлж чадахгүй, амтгүй бичиж байна**

Харамсалтай нь, зөв бичих дүрэм төдийгүй утга зохиолын хэлний хэм хэмжээг их зөрчиж байна. Уг нь нийтээр дагаж мөрдөх ёстой хэм хэмжээ шүү дээ. Гэвч би тооны хүн, эсвэл эмч юм чинь надад хэлний асуудал хамаагүй. Дунд сургуулийн багш, хэвлэл мэдээлэл, эрдэмтэд л хариуцна биз гэсэн гаж ухамсар нийтэд тогтчихож.

Мөн мэдээллийн хэрэгсэлээр гарч буй аль ч салбарын хүний хэл яриа хойч үедээ үлдгэр дуурайл болж явдаг. Тиймээс хэл яриагаа цэнэж ярих нь чухал. Манай улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын байгууллага ч монгол хэлний хэм хэмжээг мөрдөх ёстой. Гэвч ийм ухамсар олон нийтэд бүрэлдээгүй байна.

**Энэ буруу хэвшлийг нэг талаар олон нийтийн сүлжээ их дэвэргэж байгаа болов уу?**

-Тийм ээ. Хүүхэд, залуучуудын хэллэг ч орчуулгын маягтай болж эхэллээ. Дор бүрнээ төрөлх хэлнийхээ онцлогийг хадгалж байж бусад соёлыг ойлгож сурна гэсэн ухамсартай байх ёстой. "Ингэдэг байгаа", "тэгдэг байгаа" гэх мэт яриа нь анхандаа залуучуудын этгээд үг хэллэг мэт байсан ч нийгэмд байр сууриа эзэлсэн, олны танил хүмүүс хүртэл ингэж яриад байна шүү дээ. Энэ бол олон нийтийн сүлжээний харь соёлын түрлэгийг барьж чадахгүй байгаагийн илрэл.

Мөн ярианы хэлний "сан" төгсгөлөөр бичгийн хэлэнд өгүүлдэрээ төгсгөх жишиг



С.Батсайхан / ЗГМ

хэвлэл мэдээллийн хэрэгсэл төдийгүй судлаачдад тогтсон байна. Энэ бол аюулын харанга. Ийм буруу жишиг манайхаас өөр оронд байхгүй. Эмнэлгийн байгууллага нь хүртэл оношилгоо, зовуурь гэх мэт үгээ буруу бичиж байна шүү дээ.

**Тэгвэл гадаад хэлний багш нарын эх хэлний мэдлэг болон заах аргатай нэг талаар холбоотой болов уу?**

-Гадаад хэлний багш, орчуулагч нар гаднын соёлыг нэвтрүүлж буй буянтай хүмүүс. Гэхдээ хоёр соёлын гүүр болж байгаагийн хувьд төрөлх хэлтэйгээ харьцуулж заах арга барилыг сайн эзэмшсэн байх хэрэгтэй. Оюутнууд гадаад хэлний тэмдэг нэрийн шинжийн дарааллыг сүрхий нэрлэдэг. Гэвч "цахим ухаалаг сургалт" ба "ухаалаг цахим сургалт", "тарган сайхан зээрд морь" ба "зээрд тарган сайхан морь" гэдгээ аль нь зөвийг мэдэхгүй л байна.

Өсвөр үеийнхэн, залуучууд маань харь хэлний үндсэн сэтгэлгүй түлхүү сурч, улмаар бүтцийг нь өөрчлөгдөж байгаагийн илрэл энэ. Үүний улмаас үг, өгүүлдэрийг гадаад хэлний бүтцээр төрөлх хэлэнд махчлан буулгах гэж зүтгэдэг буруу зуршил газар авдаг. Эргээд ийм зүйлийг хүүхэд уншихаар

сэтгэл нь ямар болж төлөвших нь ойлгомжтой. Цаашлаад, хүний танин мэдэхүй орчуулгын найруулга зонхилсон мэдээллээр хязгаарлагдаж байна гэсэн үг шүү дээ.

### Үр хүүхдээ унаган харь хэлтэй болгох хүслийг гаднынхан ойлгодоггүй

**-Орчуулгын тухайд, сүүлийн үед нэг бол тайлбарласан, эсвэл яг дуудлагар нь буулгасан харь үг ихэсчээ. Тухайлбал, "hedge", "offshore" гэх мэт?**

-Б.Ренчин гуай "Орчуулагддаггүй үг гэж байдаггүй, харин орчуулж чадахгүй орчуулагч гэж байдаг" хэмээсэн. Шинээр үзэгдэл, юмс, ойлголтыг тайлбарлан орчуулах практик өнөөдөр эдийн засгийн салбарт их ажиглагдаж байна. Товч, тодорхой буулгах нь орчуулагчийн хэлний чадвар, мэдлэгээ шалтгаалдаг. Хамгийн гол нь бид ийм үгсийг орж ирсэн даруйд нь уухайн тас моод,

чамирхал болгож хэрэглэхийд байна. Тиймээс тухайн салбарын эрдэмтэд тэрхүү нэр томъёогоо цэгцлэх үүргээ сайн биелүүлэх хэрэгтэй. Гол нь, харь үгээ орчуулж хэрэглэх нь зөв гэсэн ухамсартай байх ёстой.

**-Цэг, таслал зэрэг 35 үсэгнээс бүрдэж тэмдэгт сүүлийн үед бараг мартгагдах дөхжээ?**

-Яг үнэн. Цэг тэмдэгт бол бичгийн хэлэнд хүний сэтгэлийн хөдөлгөөнийг хамгийн тодорхой илэрхийлдэг. Зүйрлэвэл, ярианы хэлэнд биеийн хэлэмж гэсэн үг. Тиймээс ч, цэг тэмдэгтийн хэрэглээ баруунд бол эссений хамгийн чухал шалгуурт ордог. Харин бид хаалт, хашилт хоёроо ч ялгахгүй байна. Цэг, тэмдгийг үл тоож байгаа нь бид бичгийн хэлээр сэтгэлийн хөдлөл, хандлагаа илэрхийлж чадахгүй, амтгүй бичиж байна гэсэн үг.

Социализмын үед хэвлэл мэдээллийн нэг л хэрэгсэлтэй, хэл бичгээ ариутгадаг тогтсон нэг л газар байлаа. Миний үеийнхэн алдаагүй орчинд өссөн учраас алдаагүй бичээд сурсан. Ингээд бодохоор манай хүүхэд залуусын ч буруу биш шүү дээ.

**-Монгол хэлийг сонирхолтой, хүртээмжтэй заах асуудал чухал болов уу?**

-Бага ангид зөвхөн монгол хэлний дүрэм үздэг. Үгийн бүтцээ

заахдаа ч мөн дагавар, нөхцөлөөр нь салгаад орхичихдог. Дагавар, нөхцөлийн зааг дээр ямар зүй тогтоол, хууль үйлчилж байж үг бүтдэг вэ гэсэн хэрэглээ талыг заах нь дутмаг байна. Дараа нь найруулга зүй ороход зөвхөн өгүүлбэрийн гишүүд гээд зуруулаад орхичихдог. Бас л гишүүн өгүүлбэрүүд өгүүлэхүүн, өгүүлэгдэхүүний хаана байрладагийг заахгүй, зөвхөн тусдаа салангид зүйлс юм шиг л цээжүүлчихдэг.

Үүний үр дагавар нь их, дээд сургуульд элсэгчдийн хэлний мэдлэгээс харагдаж байна. Шинжлэх ухааны найруулга үзэж, практикаар орох ёстой хичээл өнөөдөр лекц хэлбэрт шилжихсэн. Хүн бодол санаагаа сэтгэлийн хөдөлгөөнтэй, албан ёсны гэх мэтээр илэрхийлж, нийгэмд харилцаа үүсгэх нь л эцсийн дүндээ чухал.

**-Бид нэг хил хязгаарын дотор оршдог, нэг цул үндэстэн боловч бараг л дур дураараа бичих юм. Үүнийг яаж засах ёстой вэ?**

-Нэг дүрэмтэй хэрнээ маргаад байж боломгүй. Би монгол хүн учраас монголоор ярина. Харин монгол хэл бол хэл зүйн нэг л дүрэмтэй гэдгийг хүн бүр ойлгох хэрэгтэй. Бас толь бичиг байхад үгийг зөв бичих тухайд эргэлзэх ямар ч шаардлага байхгүй. Төрийн хэлний зөвлөл крилл бичгийн дүрмийг ойрын үед өөрчлөхгүй гэсэн бодлого баримталж байна.

Крилл бичгийн дүрмийг маш сайн зохиосон гэж би мэргэжилтний хувьд хэлбэ. Ц.Дамдинсүрэн гуай үүнийг босоо монгол бичгийг баримталж зохиосон юм. "Хонь" гэдэг үгийг "хони" гэж бичсэн ч орос сургагч "хони" гэж уншаад байсан гэдэг. Тэгээд арга буюу "б" тэмдэг тавьж, босоо монгол бичгийн "хони", "мори" хэлбэрээс тагталзсан гэж Ц.Шагдарсүрэн профессорын "Эх хэлээ эвдэхгүй юмсан" бүтээлд бий. Ерөөс "б" нь "и" болох дүрэм гарч ирсэн нь ийм учиртай.

**-Манай хэл зүйн дүрмийг урт настай гэдэг. Харин хувьсал нь чухам хаана явагддаг юм бэ?**

-Аливаа хэл бичиг олон жил орших тусмаа соёл болж тогтдог. Босоо монгол бичиг бол 800 гаруй жилийн түүхтэй. 1980-аад онд Баруун Германы дэлхийн соёлын түүхийн номонд дэлхийд он удаан хэрэглэгдсэн 13 бичгийн наймдугаарт босоо монгол бичиг орж байсан.

Энэ бичиг "абу", "өргүгэ" гэх мэт хаа байсан XIII зууны үеийн хүмүүсийн хэл ярианы онцлогийг тусгасан. Харин өвөр монголчууд одоо ч гэсэн энэ хэлийг хэрэглэж байна. Тиймээс хэлний хувьсал бид аман хэлэнд явагддаг. Харин бичгийн хэл нь аман хэлэндээ тулгуурлан хөгжиж байдаг зүй тогтолоо.

Гэтэл залуусын ярианы хэлэнд "лайкдах", "шейрлэх" гээд гадаад хэл ороод ирлээ. Энэ

үнэхээр хэлний хувьсал уу гэдэг нь сонин байна. "Нандин" зэрэг үг шиг эдгээд, уусаад ирвэл өөр хэрэг. Харин одоогийн нөхцөлд харь үг хэллэг манай хэлийг баяжуулахаас илүү бохирлож байна гэж мэргэжилтнүүд үздэг.

Тиймээс Л.Лувсанвандан, Ц.Дамдинсүрэн, Б.Ренчин зэрэг том эрдэмтдийн алсын хараатай, бодлоготой хэлж байсан үгсийг бид сэргээх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, зөвхөн зөв бичгийн дүрмийн хүрээнд эргэлдэх бус бүхэл бүтэн улсын сэтгэлгээний соёлын түвшинд хэлний бодлогоо зохицуулах ёстой.

### Толь бичиг байхад үгийг зөв бичих тухайд эргэлзэх шаардлагагүй

**-Монгол хэлний үгсийн сангийн хэчнэн хувь нь харь үг байгаа вэ?**

-Энэ талаар судлаачид ид ажиллаж байгаа. Гэхдээ үүнийг тооцож ядах юмгүй. Зонхилон хэрэглэдэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн нэг дугаарыг шүүгээд, гадаад, дотоод үгсийн харьцааг гаргаад ирнэ. Бас бидний хөдөө, хотгүй ордог фейсбүүкт "орк", "эмо" зэрэг янз янзын үг явж байна. Харь үгийн хэрэглээг хэнээр ч хэлүүлэлтгүй бид өөрсдөө мэдэрч байгаа биз дээ.

**-Хүүхдээ унаган гадаад, эсвэл "bilingual" буюу хос хэлтэй болгох хүсэлтэй хүмүүс олширчээ. Та мэргэжлийн хүний хувьд үүнд ямар тайлбар өгөх вэ?**

-Хавтгайрсан биш тусгай бодлогоор хэрэгжих ёстой. Олон улстай эдийн засаг, хөгжлөөрөө зэрэгцэж явахын тулд бид ямар хэлээр хос хэлтэн бэлтгэх шаардлага тулгарч байгааг харгалзах хэрэгтэй болов уу.

Өөрөөр хэлбэл, төрийн хар хайрцагны бодлогоор зохицуулна. Түүнээс биш бүх нийтээр хүмүүсийнхээ сэтгэлгээг эвдэх шиг аймшигтай аюул байхгүй. Унаган жилийн хэлтэй болгохыг хэдэн жилийн өмнө Японы нэг эрдэмтэн ихэд шүүмжилж байсан. "Үр хүүхдээ унаган герман, япон хэлтэй болгох гэсэн монголчуудын занг ойлгохгүй байна. Монгол хүний унаган хэл монгол л байх ёстой.

Харь хэлийг унаган болтол эзэмшүүлснээр монголчуудад ямар ашигтай юм бэ" гэж байсан. Энэ бол үнэн. Хүний төрөлх хэл бол эхийн хэвлийд байх үеэс тархинд нь суудгийг сүүлийн үеийн судалгаанууд баталж байна. Гэтэл харь хэлийг унаган хэл болгож эзэмшүүлнэ гэхээр эхийн хэвлийд бүрэлдсэн сэтгэлгээг нь өөрчилнө гэсэн үг шүү дээ. [ЗГМ]

### Эшлэл



-Хүүхэд бүрийг монгол хэлний хэрэглээний бүрэн чадвартай болгох, монгол соёл, зан заншил, уламжлалыг өвлөх, уламжлах, хөгжүүлэх чадамжтай болгох нь монгол сургалтын хөтөлбөрийн язгуур шаардлага болдог. Энэ шаардлагын үүднээс хөтөлбөрийг дахин үнэлэх, боловсронгуй болгохоор ажиллаж байна. Монгол хэлний сургалтад онцгой ач холбогдол өгнө.

БСШУС-ын сайд  
Ж.Батсуурь

### ТЭТГЭЛЭГ

## Европын есөн сургуульд суралцах тэтгэлэг үргэлжилж байна

Европын комиссоос санхүүжүүлдэг Эрасмус Мундус төслийн "gLink" тэтгэлэгт хөтөлбөрийн гуравдугаар ээлжид хамрагдах хүсэлтэй оюутнуудын материалыг хүлээн авч байна.

Тэтгэлэгт хөтөлбөр нь хөдөө аж ахуй, архитектур, хотын ба бүсийн төлөвлөлт, бизнес судлал, менежмент, боловсрол ба багшлах арга зүй, инженер технологи, анагаах ухаан, байгалийн шинжлэх ухааны чиглэлд хэрэгжиж буй юм. 2015-2018 онд хэрэгжиж байгаа уг хөтөлбөрт манай улсаас нийт 11 оюутан хамрагдах боломжтой. Оюутнуудад

Европын түнш есөн их, дээд сургуульд бакалавр, магистрт тус бүр 10 сар, доктор 27 сар, докторын дараах 10 сарын сургалтад хамрагдах тэтгэлэг олгох юм байна. Харин багш, ажилтнууд нэг хүртэлх сарын сургалтын тэтгэлэг авна.

"gLink"-ийн гуравдугаар ээлжийн тэтгэлэгт хоёр талын нислэгийн тийз 2000 хүртэлх, эрүү мэндийн даатгал, сарын 1000-2500 еврог тооцож олгох юм байна.

Тэтгэлэгт хамрагдах хүсэлтэй материалыг энэ сарын 15-ныг дуусгал <http://glink-edu.eu/> хаягаар хүлээн авч буй аж. [ЗГМ]

## Оюутны сургалтын зээл авах боломж бүрдэв

Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн төрийн болон төрийн бус өмчийн бүх их, дээд сургууль, коллежийн оюутан бүрт нээлттэй "Оюутны хөгжлийн зээл"-ийн гэрээг баталлаа.

Ийнхүү 2016-2017 оны хичээлийн жилд 70 гаруй мянган оюутан сургалтын зээл авах боломж бүрдлээ. "Оюутны хөгжлийн зээл"-ийн гэрээг "Төрийн банк", "ХААН банк", "Голомт банк", "Улаанбаатар хотын банк", "ХАС банк", "Капитрон банк"-аар дамжуулан байгуулах боломжтой аж. Энэ хичээлийн жилийн зээлийн эх үүсвэрт нийтдээ 200 тэрбум

төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн байна.

Энэхүү зээлийн үйлчилгээг бий болгосноор оюутнуудын сургалтын төлбөрийн дарамт багасах, төгсөөд ажилтай, орлоготой болох хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой юм. Мөн сургалтын чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр болно гэж тооцожээ.

Зээлийн эргэлтийн болон хуримтлалын хөрөнгийг үүсгэх зорилгоор улсын төсвөөс 2020 он хүртэл "Оюутны хөгжлийн зээл"-ийг санхүүжүүлэх юм. [ЗГМ]



"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шуудагч ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон урлагч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга

Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Тэргүүлн орлогч эрхлэгч

Цэвэрэндоржийн ЦЭВЭЭНХЭРЛЭН

Утас: 99901526

Орлогч эрхлэгч

Лхагважавын СУГАРМАА

Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба

Эдитор Б.Гандолгор

Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба

Эдитор Р.Оюунцэцэг

Утас: 99901621

Гадаад контент, соёл энтертайментын алба

Эдитор Б.Энхжаргал

Утас: 99901682

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн

Утас: 99903581

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

1 хороо, Энхтайвны өргөн чөлөө,

"Бло Скай тэвэр" 407 тоот

Улсын бүртгэлийн дугаар: 1024

Утас: 70103131,

Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Co

"Чөлөөт хэвлэл"

сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв

Дугаарын удирдагч

Б.Гандолгор





## Амьдралын хэв маяг



Мэргэжлийн эмнэлгүүдэд уруулын филлэрийг 300 орчим паундаар хийдэг. Харин ботоксыг зөвхөн нэг хэсэгт хийхэд л 199 паунд байдаг нь манайхаар бол 600 орчим мянган төгрөг юм.

NYT©

# Гоо сайхан золиос шаарддаг

**Гоо сайхны газрууд гурав дахин хямд үнээр ботокс хийдэг**

Г.Сайнзаяа  
@sainzayaZGM

Цагаан арьст хүмүүсийн дунд хөх, бөгс, уруулаа томсгож, шанаа нарийсгах, хацар дүүргэх ботокс, филлэр эрчээ авч байна. Манай улсад ч гоо сайхны эмнэлгүүд энэ төрлийн үйлчилгээг үзүүлж эхлээд багагүй хугацаа өнгөрлөө.

Ботокс, филлэрийн давуу тал бол мээ хүргэлгүйгээр, богино хугацаанд хүссэн үр дүндээ хүрэх явдал юм. Мэдээ алдуулж, хэдэн газар тарианаар шингэн

шахахад л ажиллагаа дуусч байгаа нь тэр. Ботокс, филлэр нь хүний биед бүрэн задардаг уураг тул эхний удаад 3-6, хоёр дахь удаад 6-9 сар болоод уусан алга болдог. Товчхондоо, байнгын давтамжтай хийлгэх шаардлагатай гэсэн үг. Ботоксыг булчингийн хэт хувирлаас үүдэлтэй үрчлээг тэнийлгэх зорилгоор хийнэ. Харин филлэрийг нүүрний унжсан, хонхойсон хэсгийг тэлэх маягаар хийдэг байна.

Монголд энэ чиглэлээр найман жилийн турш үйл ажиллагаа явуулж буй "Dermaesthetic Beauty" эмнэлгийн эмч А.Хатанзул "Гоо сайхан, эмчилгээний зориулалтаар ботокс, филлэр хийх эрхийг тусгай зөвшөөрлөөр олгож, нарийн мэргэшсэн эмч нар хийж гүйцэтгэдэг. Гоо сайхны газруудад хямд үнээр хийж байгаа нь ариун цэвэр, чанарын шаардлага хангасан,

эсэх нь эргэлзээтэй. Ер нь охид бүсгүйчүүд ботокс, филлэрийг их хийлгэдэг. Хагалгаа биш, ерөнхийдөө аюулгүй эмчилгээний төрөлд багтдаг юм" хэмээлээ.

Үйлчлүүлэгчдийн дийлэнх нь хүрсэн үр дүндээ сэтгэл ханамжтай байдаг болохоор жил ирэх тусам хүрээгээ тэлсээр. Зөвхөн Их Британид л гэхэд 3.6 тэрбум паунд энэ салбарт эргэлдэж байна. Гэхдээ цар хүрээ нэмэгдэхийн хэрээр салбарыг бүхэлд нь хянах аргагүйд хүрч байна. Түүнчлэн аюулгүй байдал, сөрөг үр дагавар нь эрдэмтэн судлаачдын анхаарах асуудал болжээ.

Бүтэн нэрээ хэлэхээс татгалзсан 24 настай Тина "Филлинг хийлгэж дуусаад би маш их уйлсан. Өөрийгөө балласан юм шиг л санагдсан даа. Бүх зүйл маш хурдан бас хялбар болоод өнгөрсөн. Нэг

мэдэхэд уруулаа томруулчихсан байсан. Орой нь би амьдралдаа хэзээ ч мэдрээгүйгээрээ их өвдөж байлаа. Уруул минь тэсрэх гэж байгаа юм шиг л" гэв. Энэ төрлийн үйлчилгээг Их Британид заавал мэргэжлийн эмч гүйцэтгэх шаардлагагүй тул зөвшөөрөлгүй газрууд олширчээ. Тина шинэ уруулаандаа 75 паунд зарцуулсан байна. Мэргэжлийн эмнэлгүүдэд уруулын филлэрийг 300 орчим паундаар хийдэг. Харин ботоксыг зөвхөн нэг хэсэгт хийхэд л 199 паунд байдаг нь манайхаар бол 600 орчим мянган төгрөг юм.

### Филлэр, ботокс нь уураг учир хүний биед 3-6 сарын дараа уусдаг

Эхний хоёр жилд дунджаар гурван удаа, цаашид хоёр жилд нэг удаа тогтмол хийлгэвэл тохиромжтой. Ингээд бодохоор санхүүгийн боломжтой хүмүүсийн гоёо гэдэг нь илт. Гэвч зөвхөн Монголд гэлтгүй хаа сайгүй л хямд төсөр аргаар гоо сайхнаа хохироож буй хүн олон байгаа юм. Эрэлт хэрэгцээгээр нь авч үзвэл, уруул томруулахын дараа хөх томруулах үйлчилгээ бичигдэж байна. Мөн нүүрний хэлбэрийг нарийсгаж засах, хамар өндөрлөх, хөмсөг өргөх зэрэг үйлчилгээ эрэлттэй байдаг аж.

21 настай Сара туранхай, хөх гэхээр юмгүй байжээ. Удаан бодсоны эцэст мэргэжлийн бус гоо сайхны газар 500 паунд төлөөд цээжний булчингийнхаа доор имплант суулгуулжээ. Уг нь бол энэ төрлийн имплантыг 2500-7000 паундаар хийдэг байна. Ажиллагааны дараах өвдөлт тэсвэрлэхийн аргагүй байсныг тэрбээр өгүүлээд "Надад хуурамч мэдрэмж төрдөг. Шинэ залуутай болзох бүртээ би ичдэг болсон" хэмээв.

Хүний биед мээ хүргэж, цус гаргаад байдаггүй болохоор энэ төрлийн үйлчилгээг манай гоо сайхны газрууд ихээр хийх болсон. Өөрөө ч юу болохыг нь мэдэж амжаагүй байтал "Энэ их гоё, та ёстой сайхан харагдана, таван насаар залуужина" гэсээр "дарж" авах нь холгүй байдаг болж. Олон нийтийн сүлжээ, сайтаар ч сурталчилгаа их явж байгаа нь охид бүсгүйчүүдийн анхаарлыг ихээхэн татаж байгаа юм. Гэхдээ бүсгүйчүүдийн дунд шинэ хандлага болж буй ботокс, филлэрийг хийлгэхээр бол мөнгөө харамлалгүй, зөвшөөрөлтэй эмнэлэгт, мэргэшсэн эмчээр хийлгэхийг олон улсын шинжээчид зөвлөж байна. [ЗГМ]

## Өглөө рашаан, орой хор болдог хүнс

Амин дэмтэй, биед сайн хүнс хэтрэхээрээ, эсвэл зохимжгүй хүнстэй нийлэхээрээ хор болох цагт идвэл сөрөг нөлөөтэй хүнс байдаг гэж та урьд нь сонссон уу. Эрүүл амьдралын хэв маягийг сурталчлагч "Cure-Joy" цахим сэтгүүлд хүнсний бүтээгдэхүүний өдрийн аль үед идэхээс шалтгаалж хэрхэн үйлчилдгийг мэдээлжээ. Тэдний заримаас сонирхуулж байна.

**Гадил-** Гадил жимсийг өглөөний цайнд уувал бодисын солилцооны үйл ажиллагааг эрчимжүүлж, арьсыг толгоор сайхан болгодог. Харин оройн хоолонд зоогловол мөөгөнцөр үүсгэх шалтгаан болж, хоол илүүдэл саад болно.

**Алим-** Цусан дахь сахар, өөх тосны хэмжээг бууруулдаг пектин хэмээх бодис алиманд агуулагддаг. Гэвч оройн цагаар пектинийг шингээхэд хүнд бөгөөд ходоодны хүчлийг ихэсгэдэг гэмтэй.

хамгаална. Харин орой идвэл жин нэмнэ.

**Жүрж-** Хоолны дундуур жүрж идвэл бодисын солилцоог сайжруулах болно. Гэвч орой идсэн жүрж хоол гэхээсээ хор болж, ходоодыг цочроон, салст бүрхэвчийн үрэвсэлд хүргэх эрсдэлтэй.

**Улаан лооль-** Өглөөний цагаар улаан лооль идвэл хоолны шингэцийг сайжруулж, бодисын солилцоог эрчимжүүлнэ. Хэрэв орой идвэл гэдэс хий дүүргэдэг.

**Цагаан будаа-** Өдрийн цагаар хүний бодисын солилцоо эрчимтэй явагдаж байдаг. Энэ үеэр цагаан будаа идвэл түүнд агуулагдах нүүрс усыг ашиглах боломжтой. Гэвч орой идвэл илүүдэл жинтэй болно.

**Хар шоколад-** Шоколаданд агуулагдах антиоксидант пектин хэмээх бодис алиманд агуулагддаг. Гэвч оройн цагаар пектинийг шингээхэд хүнд бөгөөд ходоодны хүчлийг ихэсгэдэг гэмтэй.



**Төмс-** Эрдээр баялаг хүнс. Өглөөний цайнд идвэл төмсний цардуул цусан дахь өөх тосны хэмжээг бууруулна. Харин орой идвэл калори ихтэй тул жин нэмдэг.

**Сүү-** Бүлээн сүү унтахын өмнө балгыг уувал сайн амарна. Гэвч өглөө сүү уусны дараа идвэхтэй дасгал хөдөлгөөн хийхгүй бол шингэхгүй. Гэдэс дүүргэж, цусан дахь сахарын хэмжээг нэмэгдүүлнэ. Мөн харшилтай болох эрсдэл өндөр.

**Самар-** Самарыг өглөө идвэл цусны даралт ихсэхээс

идвэл илүүдэл жинд хөтлөх магадлалтай.

**Хатаасан чангаанз-** Чангаанзыг өглөө идвэл бодисын солилцоог сайжруулж, хоол шингээх үйл явцад ходоодыг бэлддэг. Оройн цагаар үйлчилгээ нь эсрэгээрээ болж, гэдэс хий дүүргэх, хоол шингээлтийг саармагжуулна.

**Бяслаг-** Өглөөний цайнд бяслаг идвэл таргалалт, өөхлөлтөөс сэргийлэх боломжтой. Оройн хоолонд зоогловол шингээхэд хүндрэлтэй тул өөхлөлтийг нэмэгдүүлнэ. [ЗГМ]

### Ану зайрмагт дуртай



**Олны танил алдартай бүсгүйчүүд эрүүл хооллож, дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэсний үр дүнд бие галбир өв тэгш байдаг. Ганц хөдөлгөөнөөр турахад хэцүү болохоор хооллолт тун чухал. Бид алдартай бүсгүйчүүдийг хэрхэн хооллодогийг сонирхлоо. Эхний удаад "Гурван охин" хамтлагийн гишүүн Х.Алтанхишиг буюу Анугийн хөргөгчийг "уудалсан" юм.**

**-Ану өдөрт хэдэн удаа хооллодог вэ?**

-Өглөөний цайгаа уугаад, өдрийн хоолоо сайн идэж аваад, орой хоол иддэггүй.

**-Бид таны хөргөгчийг онгойлгоод маш их гайхахаар зүйл бий юу?**

-Гайхмаар зүйл гэхээр сайн мэдэхгүй юм даа. Ааруул бол байнга л байдаг.

**-Амтганд дуртай юу. Хэзээ ч татгалзаж чадахгүй нэг амтганаа нэрлээч?**

-Би зайрмагт маш их дуртай. Тэр дундаа хатуу, шаржигнадаг жигнэмэгтэй зайрмагнаас бол татгалзаж чадахгүй.

**-Хэрэв би таны гэрт нэг оройг өнгөрүүлэхээр болбол та ямар хоол хийж өгөх вэ?**

-Миний гэрт оройг өнгөрөөвөл би гоё нэг, хоёрдугаар хоол хийж өгнө. Нэгдүгээр хоол нь борц юм уу ногоотой шөл. Тэгээд л амттай хуурга хийнэ дээ.

**-Анугийн цуйван хийх тусгай жор гэж байдаг уу?**

-Гурилыг нь тусад нь жигнэж хийдэг.

**-Эрүүл биш гэдгийг нь мэдсэн ч идэх дуртай амны зугаа юу вэ?**

-Чипс.

-Баярлалаа. [ЗГМ]

Та доорх кодыг уншуулж Засгийн Газрын Мэдээ Financial Times сонинг нэг дороос уншина уу

Та QR code уншуулахын тулд App Store-оос QR reader татаж суулгана уу.

70103131  
info@zasag.co  
UBinfo.mn

# UBinfo.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ  
СОНИН АМЬ



## Кино

## Үл мартагдах Жаки



Жон Кеннедигийн хөнгөмсөг зан, бие давхар байхдаа анхны хүүхдээ алдсан нь түүний амьдралын сүүдэр.

## 30 настай Форрест Гамп

“Форрест Гамп” киноны “баатар” 30 нас хүрлээ. Уинстон Грум 1986 онд “Форрест Гамп” зохиолдоо дэлхийд алдартай “баатар”-ыг амилуулсан түүхтэй. 1994 онд жүжигчин Том Хэнксийн тогосноор дэлгэцийн бүтээл болсон тус киноны талаар сонирхолтой баримтуудыг хүргэж байна.



## Киноны хамгийн түгшүүртэй хэсэг нь Жон Кеннедид халддаг үе

Б.Баярмаа  
@bayarmaaZGM

АНУ-ын 36 дахь Ерөнхийлөгч Линдон Жонсоны тангараг өргөх ёслол дээр нэгэн эмэгтэй цусны толбо болсон “Channel”-ийн ягаан хослолтой иржээ. Хэвлэлийнхэн, олон нийтийн хараа түүний зүг чиглэнэ. Тэр бол АНУ-ын 35 дахь тэргүүн хатагтай Жаклин Кеннеди. Нөхөр Жон Кеннеди нь түүний дэргэд толгойдоо буудуулан амиа алдахад тэрбээр энэ хувцсаа өмсөж байжээ. Тиймээс түүний нөхөрт юу тохиолдсоныг хүмүүс дурсаг хэмээн цусны толботой хослолтойгоо ирсэн аж. Он цаг улирсан ч дэлхий нийт энэ сэтгэл шимшрүүлэм мөчийг мартсангүй.

Жаклин Кеннедигийн алдар нэрд умбасан хэрнээ эмгэнэлт амьдралын түүхийг өгүүлэх “Жаки” кино маргааш нээлтээ хийх гэж байна. “Fox Searchlight Pictures”-ийн бүтээл уг кино есдүгээр сард Венецийн болон Торонтогийн олон улсын кино наадмын дэлгэцнээ гарч, гурван шагнал авсан. Мөн өнгөрсөн сард болсон “Hollywood film awards”-аас гол дүрийн жүжигчин Натали Портман шилдэг эмэгтэй жүжигчний шагнал гарджээ. Цаашид ч цөөнгүй шагнал “түүнээ” гэж кино шүүмжлэгчид үзэж байна. Тус кино маргааш АНУ-д нээлтээ хийх бол ирэх оны нэгдүгээр сард олон улсад гарах аж.

Зохиолч Ноа Опенхайм Жаклин Кеннедигийн Цагаан ордонд өнгөрүүлсэн өдгүүд болон алага болсон 1963 оны арваннэгдүгээр сарын 22-ны өдрийг тодотгожээ. Тэрбээр Жаклин Кеннедигийн амьд ахуйдаа “Life” сэтгүүлд өгсөн ярилцлагаас цөөнгүй баримт, санаа авсан байна. Мөн Жон

Кеннедигийн туслхаар ажиллаж байсан Артур Шлезингерт өөрийн амьдралаа ярьсан найман цагийн бичлэгийг нь ашиглажээ. Опенхайм өмнө нь Стивен Стилбергтэй хамтарч “НВО” сувгаар экс тэргүүн хатагтайн тухай цуврал кино хийж эхэлсэн ч хамтрагч нь замын дундаас буцжээ. Харин 2010 онд бүрэн хэмжээний кино хийхээр болж, 2012 онд Натали Портманыг Жакины дүрд тоглуулахаар сонгосон аж. Энэ шийдвэр найруулагч Пабло Ларрены хамгийн зөв шийдэл байсан гэж шүүмжлэгчид үзэж байна. Тэд Натали Портман түүхэн эмэгтэйн дүрд чадварлаг тоглосон гэдэгт санал нэгджээ.

Баян чинээлэг айлд өссөн Жаклин Цагаан ордонд ирсэн даруйдаа бүх засал, чимэглэлийг өөрчилсөн. Тэр хүссэн хүнтэйгээ уулзаж, хүссэн газар руугаа аялдаг байлаа. Түүний өмссөн бүхэн грэнд болдог байв. Гэвч бүсгүйн Цагаан ордон дахь алдар нэрд умбасан амьдрал төгс байгаагүй. Жон Кеннедигийн хөнгөмсөг зан, бие

давхар байхдаа анхны хүүхдээ алдсан нь түүний амьдралын сүүдэр байлаа. Жаклин 1963 оны арваннэгдүгээр сарын 22-нд болсон аллагын хамгийн ойрын гэрч.

“Киноны хамгийн түгшүүртэй хэсэг нь Жон Кеннедид халддаг үе. Би тэр үеийн бичлэгийг хэдэн арван удаа давтаж үзсэн. Жаклин энэ бүхнийг биеэрээ туулсан учраас тэр хэсэг хамгийн хэцүү нь байсан” гэж Натали Портман “Time” сэтгүүлд ярьжээ. Тэрбээр “2015 оны арваннэгдүгээр сард Парист зураг авалт хийсний дараа яг тэр газарт 130 хүн амиа алдсан террорист халдлага болсон. Тэнд амиа алдсан хүмүүсийн ар гэрийнхэнд ямар байсан шиг, Жаклинд ч бас тийм хэцүү байсан биз” хэмээн өгүүлжээ.

“Жаки” киноны үзэгчдийг татаж буй бас нэгэн “соронз” нь Жаклин Кеннедигийн хувцас. Тэрбээр хамгийн залуудаа АНУ-ын тэргүүн хатагтай болсон эмэгтэй. Жон Кеннеди Францад айлчлах үеэрээ “Танилцахыг зөвшөөрнө үү. Би

Жакиныг Парист дагаж яваа хүн байна” хэмээн хошигнож байжээ. Түүний гоо үзэсгэлэн, загварын мэдрэмжийг гүйцэх тэргүүн хатагтай одоо хүртэл гарч ирээгүй гэлцдэг.

Кинонд Жакиныг ямар хувцастайгаар дүрслэх нь бүсгүйчүүдийн сонирхлыг татаж байлаа. Үүнд найруулагч дээр дурдсан “Channel”-ийн ягаан хослолоор тодорхой хариулт өгсөн юм. Нөхөр нь амь үрэгдэх мөчид өмсөж байсан тэр хувцсыг кинонд ахин урлажээ. Тухайн үед загварын бэлгэ тэмдэг болж байсан Жакины хувцсуудыг гэрэл зургуудаас нь харж, ахин бүтээсэн байна.

Жаклин Кеннеди таван жил бэлэвсэн явсны эцэст Грекийн тэрбумтан Аристотель Анасистой гэрлэсэн. Хоёр дахь нөхөр нь 1975 онд нас барсны дараа тэрбээр номын редактораар ажиллаж байгаад 1994 онд хорт хавдрын улмаас нас барсан. Гэхдээ “Жаки” кинонд түүний амьдралын сүүлийн жилүүдийг дурдаагүй юм. [ЗГМ]

-Америкийн кино нийгэмлэгээс тус киног сүүлийн 100 жилийн шилдэгийн тоонд багтаажээ.

-Киног 55 сая ам.доллараар бүтээж, 677 саяын ашиг олжээ.

-Тус кино “Оскар”-ын наадмын 13 төрөлд нэр дэвшиж, зургаан шагнал хүртсэн юм.

-2014 онд тус киноны 20 жилийн ойг сүр дуулиантайгаар тэмдэглэсэн.

-Форрест Гампын АНУ-ын Ерөнхийлөгч Жон Кеннедигийг уулзаж буй зургийг компьютер графикийн аргаар эвлүүлжээ.

“Эж минь амьдрал яг шоколадны хайрцаг шиг гэж үргэлж хэлдэг байсан. Чи түүнийг задлахаасаа өмнө дотор нь юу байгааг мэдэхгүй” гэсэн Форрест Гампын үг дэлхийн шилдэг эшлэлүүдийн тоонд ордог.



# UBshop.mn

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМ

## Юу авмаар байна? Юу зармаар байна?

## АВТОМАШИН

- 1 Toyota Vitz зарна. 2010 онд үйлдвэрлэгдсэн. 2016 онд орж ирсэн. Утас: 88001123
- 2 Автомашинны хагарч цуурсан шил наагч зарна. Хүргэлттэй. Үнэ: 35000 Утас: 99679962
- 3 Шинэ дугуйнууд зарна. Үнэ: 100.000 төгрөг Утас: 88006734
- 4 Agiom шинэ дугуйнууд зарна Утас:99101688 /Үнэ тохирно/
- 5 2009 оны "FX35" хямд зарна. Үнэ: 25 сая Утас: 99111468
- 6 "G500" загна 2004-2012. Дотор гаднагүй он залуу болгосон машин оролцуулна. Утас: 99993434
- 7 2003 оны 2012 орж ирсэн сувдан цагаан өнгөтэй, beams-2.0 мотортой, ухрах камертай "Grand mark 2" яаралтай зарна. Үнэ 5 сая. Утас: 96651794
- 8 2009 оны "HUMMER H2" зарна. Утас:91777877
- 9 2008 оны "LX570" зарна. Үнэ:60 сая Утас: 99111468
- 10 "Full option A8" зарна. Утас: 89995108
- 11 "Sonata 6" маш хямд зарна. 2-3 хоногийн өмнө орж ирсэн. Утас: 94981894 , 88067150

## КОМПЬЮТЕР БА ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

- 1 Гэр болон оффиссын сүлжээ хүрдэггүй газарт сүлжээ дахин дамжуулагч суурилуулна. Угсралт тохиргоо үнэгүй. Утас: 75752020
- 2 Black iPad mini Wi Fi 64GB багтаамжтай. Үнэ: 400.000. Утас: 88998138
- 3 iPad1 wifi 16gb зарна. Утас: 99002508
- 4 Төмөр гадаргуутай 2ТВ багтаамжтай зөөврийн hard диск зарна. Утас: 98886655
- 5 "Sony Vaio core i5" notebook хямд зарна. Үнэ:500.000 Утас:88102740
- 6 Sony 15.6 Core I7 560-d зарна. model VPCF133FX Intel(R) Core(TM)i7 Q740 1.70 ghz Ram 4g hhd 500gb Display 15.6 inch numlock Утас: 88771767
- 7 "Kory notebook shop" бүх төрлийн used нөтбүүк, таблет худалдаалж байна. Үнийн хувьд хамгийн хямд, өргөн сонголттой. Өдөр бүр 11.00-20.00 цагийн хооронд ажиллана. Утас: 89997986
- 8 Wifi хүч нэмэгч дамжуулагч суурилуулна. Утас: 75752020

## ҮЛ ХӨДЛӨХ

- 1 Америк элчингийн урд 2-3өрөө байр зарна 11-р хороололд Америк элчингийн урд талд 2-оос 3 өрөө байр зарна. СБД-ийн хажууд Америк элчингийн урд тал-д, 11-р хороолол, 1989 оны, 70,63 м.кв, 3-н өрөө 55,21м,кв 2-р өрөө 9 давхарын 3-9 давхарт, тавилгагүй, гал тогоо тусдаа, ариун цэврийн өрөө тусдаа цэвэрхэн, өвөлдөө дулахан, наран талруу харсан цонхтой 2-3 өрөө сайхан байр зарна. /1-мкв 1,700,000-1.650.000/ Утас:91904010
- 2 10-р хороололд Сувилахуйн сургуулийн хойно 47м.кв хоёр өрөө байр зарна. Утас: 88192130
- 3 Төмөр замд СОТ-н таван давхарт угсармал байрны хоёр өрөө байр зарна. Утас: 99466494
- 4 Урлан бүтээх төвийн хойно байрлалтай. "Хурд" констракшн барьсан, ванн, жорлон тусдаа бүх цонх наран тал руугаа харсан байр. Том тагттай. Утас: 91181618
- 5 Хан-Уул дүүрэгт Peace town хотхонд 58.92м.кв байр зарна машин оролцуулж болно. Утас: 99097639
- 6 Модны 2-т угсармалын гурван өрөө байр зарна. Утас: 99105070
- 7 2 өрөө үйлчилгээ явуулах боломжтой байр зарна БЗД 8-р хороо Баянзүрх хотхон 108-р байрны 1-р давхарт дэлгүүр, сургалт, цэцэрлэг, үйлчилгээ явуулах боломжтой 43 мкв 2 өрөө байр хямд зарна. Хаяг: Офицрийн тойргоос уруулаад Баянзүрх хотхон 108-р байр Утас: 80612065

## НОМ, ХЭВЛЭЛ

- 1 Бүх төрлийн ном хэвлэл худалдаалж байна. Утас: 99144154
- 2 Хуучин номнууд зарна. Утас: 94640105
- 3 Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearsons international edition номнуудыг тус бүр 30.000 төгрөгөөр зарна. Утас 99153637
- 4 Ээж ба хүүхэд ном зарна. Утас: 99089401
- 5 Сэргэн мандалтын үеийн нэрт зураачдын бүтээлийг өнгөтөөр хэвлэж, орос хэлээр нийтэлсэн Монголд цөөн байдаг уран зургийн ном зарна. Утас: 99625921
- 6 Official guide of TOEFL TEST 4th edition. Албан ёсны TOEFL тест гаргадаг газраас уг шалгалтад бэлтгэгчдэд зориулан гаргасан GUIDE book-ийн хамгийн сүүлийн хэвлэл. Хэрэглэж байсан мөн дисктэйгээ. Утас: 99674312
- 7 Монголын залуучуудад хүн төрөлхтний хөгжлийн их алхаатай хөл нийлүүлэхийн зэрэгцээ өөрийн үндэсний зан заншил, ухамсар, ёс суртахууныхаа үнэт зүйлийг гээлгүй зөв хослуулан авч явахыг зөв ухамсарлан ойлгуулах энгийн хялбараар илэрхийлж чадсан “Монгол хүний хөгжил төлөвшилийн ДЭЭД УХААН” ном уншигчдын гар дээр очиж байна. Утас: 98111029
- 8 Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearsons international edition номнуудыг тус бүр 30.000 төгрөгөөр зарна. Утас: 99153637

## ЦАХИЛГААН БАРАА

- 1 Соронзон орны хүчээр агаарт эргэлдэх ДЭЛХИЙН БӨМБӨРЦӨГ бүхий сувенир зарна. Утас: 96012938
- 2 Германаас ирсэн мотор (generator) зарна. Цоо шинэ. Утас:99093469
- 3 Нийтийн хоолны бизнест чухал хэрэгцээтэй тоног төхөөрөмж болох хөргүүртэй шүүгээ үнэ тохиролдож яаралтай зарна. Дээд талдаа салад, ногоо зэргийг хөргөлтийн шаардлагын дагуу хадгалах найман секцтэй, доод талдаа хөргөгчтэй шүүгээтэй. /гурван сар л хэрэглэсэн/ Гадуур нийтийн хоолны тоног төхөөрөмжийн дэлгүүрт 2.600.000 төгрөгөөр худалдаалагдаж, эрэлт хэрэгцээ өндөртэй тоног төхөөрөмж юм. Худалдах үнэ: 2 саяас эхэлнэ. Худалдах доод үнэ: 1.8 сая. Утас: 75752020
- 4 Солонгосоос оруулж ирсэн сүүлийн үеийн шинэвтэр хоёр хаалгатай том хөргөгч яаралтай хямд зарна. Утас: 99236582

## ГАР УТАС

- 1 Ухаалаг цагтай байхад утсаа хаях, дуудлага сонсохгүй байх асуудалгүй боллоо. GSM сүлжээ SIM карт дэмжинэ. Дурын дугаар руу залгах дуудлага хүлээн авах боломжтой. Мессеж бичих, сэрүүлэг, цаг, pedometer, тооны машин гэх мэт олон үйлдэлтэй. Утас: 96012938 , 99818832
- 2 АНУ-аас ирсэн "iPhone 6" 16GB gold, gray. Үнэ:1.250.000 шинэ, задлаагүй. Утас:99127331
- 3 АНУ-аас ирсэн цоо шинэ задлаагүй "Factory Unlocked iPhone 6s" 16gb хар өнгөтэй утас зарна. Үнэ: 1.800.000 -гаас хямдраад 1.700.000 Утас: 99085424
- 4 Евро стандартын оригинал "Samsung Galaxy S6" утас зарна. Үнэ: 800.000 Утас: 99606293
- 5 Хамгийн сайн гэгддэг official SM-N900 note 3 зарна. Утас: 99509045
- 6 Дубайгаас авч ирсэн 18к "Vertu signature rose gold" зарна. Үнэ: 1.5 сая. Утас: 99979107

## UBSHOP.MN

ubshop.mn сайтад та зараа байрлуулбал манай сонины зарын энэ хэсэгт шууд орох юм. Зөвхөн кирил үсгээр бичсэн, холбоо барих утас, зарах үнэ нь тодорхой зарууд энэ хэсэгт орохыг анхаарна уу.





## Спорт

### Та нар морьтойгоо ирсэн үү гэх зэргээр доромжилж байлаа

Г.Баярсайхан  
@bayarsaikhanZGM

Монголчууд сагсан бөмбөгийн спортоор дэлхийн хэмжээний тэмцээнд оролцсон түүх байхгүй. Харин гурвын эсрэг гурав төрлийн оюутны ДАШТ-д Монголын шигшээ өрсөлдөхөөр болсон нь өнгөрсөн сарын том үйл явдлын нэг байв. Манай оюутан залуус энэ тэмцээнд зүгээр нэг бэлгэдлийн төдий оролцоод өнгөрсөнгүй, шилдэг багуудыг хожсоор мөнгөн медаль авсан нь багийн спортын түүхэнд тодоор бичигдэн үлдсэн билээ. Энэхүү тэмцээнд багаа удирдан оролцсон дасгалжуулагч С.Тулгатай уулзаж ярилцсан юм.

—Юуны өмнө оролцоод ирсэн тэмцээнийгээ талаар бидэнд сонирхуулаач. Хэр өргөн хүрээнд зохиогддог тэмцээн бэ?



Анх удаа ДАШТ-д ороод шууд мөнгөн медаль авсан түүх магадгүй Монголд л тохиолдож байгаа байх.

# С.Тулга: Багийн спорт хөгжихгүй гэдэг үг ард хоцорсон байх

—Хоёр жил нэг удаа зохиогддог тэмцээн. Багууд тивийнхээ АШТ-ээс эрхээ авч, энэ тэмцээнд оролцдог юм. Бидний хувьд өнгөрсөн хавар Хятадын Мүгдэн хотод болсон Азийн АШТ-ээс мөнгөн медаль хүртэж, эрхээ авсан. Монголын сагсчид дэлхийн хэмжээний тэмцээнд анх удаа орсон нь энэ. Тэмцээний цар хүрээний тухайд, Дэлхийн оюутны спортын холбоонд бүртгэлтэй 190 гаруй орноос зөвхөн эрхээ авсан шилдгүүд нь оролцдог онцлогтой.

Волейболын спорт олимпийн наадамд танхимын болон элсний гэсэн хоёр төрлөөр ордог. Үүний нэгэн адил FIBA (Олон улсын сагсан бөмбөгийн холбоо) 3x3 төрлийг олимпийн наадмын хөтөлбөрт оруулахаар хичээж байгаа. Хэрэв бүтэх юм бол монголчууд сагсан бөмбөгийн төрлөөр олимпод оролцох боломж бүрдэнэ. Яагаад гэвэл 3x3 бол монголчуудад хамгийн их тохирсон төрөл. Одоо хот, хөдөөгийн хаана ч сагсны шийд зоогоод хүүхдүүд тоглож байна. Үндсэн бааз суурь нь хангалттай байа гэсэн үг. FIBA ч гэсэн заавал

заал танхим шаардахгүй энэ төрлийг аль болох олон оронд жигд хөгжүүлэхийг зорьж байгаа.

—Бүрэлдэхүүнээ хэрхэн сонгосон бэ. Гурвын эсрэг гурав төрөлд зориулж тусгайлан бэлтгэл хийсэн байх?

—Энэ бол стандарт сагсан бөмбөгөөс арай өөр төрөл. Сая явсан баг маань хамгийн төгс хувилбар гэж болно. Б.Батзолбоо, А.Гансүх, Э.Дөлгөөн, Г.Чинбат дөрөв бол энэ төрөлд хамгийн сайн тохирсон тоглогчид. “TLG 13” баг тамирчдыг багаас нь бэлддэг байсан. Тухайн үед 8-10 настай байсан хүүхдүүд одоо том болж, амжилт гаргаад эхэлж байна. Тэд багаасаа хамт тоглосон болохоор харцаараа л бие биетэйгээ ойлголцдог.

Сагсан бөмбөгийн хоёр холбоо хэрүүл маргаантай байсныг хүмүүс мэднэ. Харин Монголын сагсан бөмбөгийн холбоо өнгөрсөн хавар хурлаа хийж, гавьяат дасгалжуулагч Ц.Цэвэрбалыг ерөнхийлөгчөөрөө сонгосон. Энэ үеэс хойш бидний дунд үл ойлголцох явдал гарсангүй. Нэгдэн нийлж, эвтэй

болсны үр дүнд энэ амжилт ирлээ гэж бодож байгаа.

—Өөрийн дасгалжуулсан багаа медаль авна, финалд шалгарна гэж бодож байв уу?

—Анх удаа ДАШТ-д ороод шууд мөнгөн медаль авсан түүх магадгүй Монголд л тохиолдож байгаа байх. Гэхдээ хэн ч хожигдоно гэж тэмцээнд ордоггүй. 3x3 амжилт гаргах магадлалтай төрөл болохоор медаль авна л гэж бодож байлаа. Зардал олдохгүй байсан ч зоригтойгоор 11 сая төгрөгийн зээл аваад явсан даа. Ингээд очоод тоглоход хэсэгтээ Хятад, Тайланд, Малайзыг хожиж, шөвгийн наймд үлдэх нь тодорхой боллоо. Дараа нь Унгарын шигшээтэй тоглоход тактикийн ялагдал хүлээж, хэсгээсээ хоёроор гарсан юм. Ингээд шөвгийн наймд Австралийн багтай таарсан. Үүнийг хэлэхэд австраличууд биднийг үл тоомсорлож, дээрнүү хандаж байлаа. “Та нар морьтойгоо ирсэн үү. Бэлтгэлдээ морьтойгоо очдог уу?” гэх зэргээр асууна. Дэлхий нийт Монголтой сагсан бөмбөгөөр танилцаж

байгаа нь л энэ тэмцээн шүү дээ. Харин бид Австралийн султальг нь ашиглаад хожчихсон. Тэгээд хагас шигшээд Азийн гурван удаагийн аварга Ливаныг хожоод аваргын төлөө тооцоолж байсны дагуу Францын багтай таарсан даа.

**Тухайн үед 8-10 настай байсан хүүхдүүд одоо том болж, амжилт гаргаад эхэлж байна**

Бид сүүлийн үед спортын сэтгэл зүйг их судалж байгаа. Манай спортод ийм зүйл дутагдалтай байдаг юм болов уу гэж боддог юм. МУИС-ийн Золзаяа гээд мундаг сэтгэлзүйч байдаг. Сая Риогийн олимпод Д.Сумьяатай ажилласан хүн. Золзаяагаас их зүйл судалж байгаад тамирчдынхаа сэтгэл зүй дээр ажилласан юм.

Манайхан нэгнийгээ тэмцээнд явахад “Очоод алаад өгнө, гарцаагүй медальтай ирнэ” гэж хоёрөгддөг. Энэ бол спортын сэтгэл зүйд байж болохгүй зүйл. Тиймээс тамирчдаа аль болох дарамт багатай явуулж, элдэв зүйл бодолгүй тэмцээнд нь оруулахыг хичээсэн. Харин аваргын төлөө тоглохын өмнө алдаа гаргачих шиг болсон. Финалд тоглох хоёр баг тодорхой болмогц Францын баг тамирчдаа аваад алга болчихсон. Харин манай багийнхан дээр монгол оюутнууд ирж баяр хүргээд, зургаа авахуулаад бөөн юм болж байгаа юм. Тэр үед францчууд шиг тамирчдаа шууд аваад явдаг байж гэж бодогдсон. Гэхдээ анхны тэмцээнээсээ мөнгөн медаль авсан нь болж байна аа.

—Манайхан сагсан дээр нуруу намдах гээд байдаг. Энэ тэмцээнд нурууны зөрүү их байсан уу?

—Бид нурууны зөрүүтэй эвлэрсэн шүү дээ. Багуудтай тоглоход 5-10 см-ийн зөрүү байсан. Гэхдээ гурвын эсрэг гурав бол дундаж нуруутай хүн зохицсон дүрэм, журамтай төрөл.

Жишээ нь нуруугаараа таван секунд шахаж болохгүй. Бас хурдан тэсэрч, богино хугацаанд ажиллахыг шаарддаг төрөл. Ер нь сүүлийн үед америкчууд ч гэсэн нурууны өндрөөр тоглохоо больчихоод байна. Дундаж өндөртэй тоглогчид багийн гол ачааг үүрэх жишээтэй. Хамгийн гол нь тэр хүн хурдтай, тэсрэлттэй, хурдан сэтгэдэг байх шаардлагатай.

Бидний энэ амжилтыг зарим хүн аз гэж бодоод байх шиг. Монголд багийн спорт хөгжихгүй ээ, монгол хүний генд нь байдаг юм гээд янз бүрээр ярьдаг шүү дээ. Харин бид монгол хүн багаар ажиллаж чадна, багийн спорт хөгжинэ гэж 12 жилийн өмнө ярьдаг байсан. Тэр үед зарим нь “Энэ мангар бацаан юу яриад байгаа юм” гээд есөн шидээр доромжилдог байлаа. Харин одоо бол багийн спорт хөгжихгүй гэдэг үг ард хоцорсон байх. Ерөнхийлөгч ч гэсэн багийн спортыг хөгжүүлэх зарлиг гаргаж, оюутны Азийн АШТ-д түрүүлсэн багийг хүлээн авч уулзлаа.

Бид өнгөрсөн хугацаанд

### ЗӨВЛӨГӨӨ

## Д.Банди: 9, 10 настайгаасаа боксоор хичээллэвэл тохиромжтой

Б.Энхжин  
ЗГМ

Боксын спортоор хичээллэх сонирхолтой хүүхэд залууст хандан Монгол Улсын ардын багш, гавьяат дасгалжуулагч Д.Банди дараах зөвлөгөөг өглөө. Д.Банди багшийг шигшээ баг удирдаж байх үед Э.Бадар-Ууган, П.Сэрдамба нар олимп, дэлхийн аварга болсон билээ. Хашир туршилагатай дасгалжуулагчийн зөвлөгөөг хамтдаа сонирхоё.

### ТОХИРОМЖТОЙ НАС

9, 10 наснаас эхэлж хичээллэвэл тохиромжтой гэж үздэг. Харин 11 нас хүрээд өсвөрийн боксчдын “Олимпийн гараа” тэмцээнд оролцож болно. Бага насны хүүхдийг боксоор хичээллүүлэхэд зарим нэг онцлог бий. Америкийн сургалтаар техник сайтай хүний хөдөлгөөнийг харуулж, өөрөөр нь дуурайлгаж хийлгэдэг. Энэ их сайн сургалт. Гол нь бага насны хүүхэдтэй ажиллахад албан ёсны техник, тактик давтахаас илүү тоглоомын аргууд ашиглан сургавал зүгээр. Бас хүүхдийг богино хугацаагаар эрчтэй бэлтгэл хийлгэж, ойр ойрхон амрааж байх хэрэгтэй. 9, 10 настай хүүхэд долоо хоногт гурван өдөр нэг цагийн бэлтгэл хийх нь тохиромжтой.



Б.Ганбаяр / ЗГМ©

Тэгээд жил ирэх тусам ачаалал нэмэгддэг явдаг.

### АМЖИЛТ ГАРГАХ МАГАДЛАЛ

Ер нь ямар ч спортод хурд, хүч, гэсвэр, авхаалж самбаа, уян хатан байж амжилт гаргадаг. Боксчин хүний тухайд үүн дээр нэмээд харааны мэдрэмж, толгойны хурдан ажиллагаа сайн байх хэрэгтэй. Ийм долоон чанар цогцолж байж амжилт ирдэг. Миний сая хэлсэн чанар зарим

хүүхдэд төрөлхөөс нь байдаг. Түүнийг нь сайн хөгжүүлэх ёстой. Мөн секцэнд орж, бэлтгэл хийснээр энэ чанаруудыг эзэмшиж болно.

Биеийн булчинг шулуун, бөөрөнхий гэж хоёр ангилдаг. Боксын спортод шулуун булчинтай тамирчин амжилт гаргах магадлалтай. Ядаж л цуцах нь бага. Мөн урт цацтай, жин хөнгөн байвал ашигтай тал болдог. Гэхдээ намхан мөртлөө хүчээ ашиглаад амжилт гаргасан

жишээ олон бий.

### СЕКЦЭНД ДӨНГӨЖ ОРСОН ХҮҮХЭД ЮУНД АНХААРАХ ЁСТОЙ ВЭ

Юуны өмнө хүүхэд тухайн спортод дур сонирхолтой байх хэрэгтэй. Өөрөө дурлаад ирэхээр аяндаа юм сурах хүсэл эрмэлзэлтэй болдог.

Бас боксоор хичээллэж эхлээд удаагүй байж тэмцээнд оролцох хэрэггүй. Ямар ч байсан цохилтоос бултаж, довтолгоо

хийж чаддаг болсон хойноо л тэмцээнд орно шүү дээ. Хамгаалалт хийж сураагүй байхад нь тэмцээнд оруулбал хүнд цохилт аваад, халшрах болно.

### ХООЛЛОЛТДОО АНХААРАХ ЗҮЙЛС

Тэмцээн уралдаан, бэлтгэл сургуулилт хийхээс хоёр цагийн өмнө хооллосон байвал зүгээр. Мөн жин их нэмдэг гурилан бүтээгдэхүүнийг бага идэх ёстой. Тэмцээн дууссанаас хойш дор хаяж 30 минут амарч байж хоолоо иддэг. Бэлтгэлийн дундуур цэвэр ус уух нь их сайн. Ус уух нь биеийн шингэний тэнцвэрийг барихад тус болдог юм. Шингэнээ нөхөж чадвал хүч тамир хэвээрээ байна.

Багаасаа боксоор хичээллэвэл тархи толгойдоо гэмтэл авах уу Өмнө нь иймэрхүү тохиолдол гарсан байж магадгүй. Харин сүүлийн үед боксын секцэнд шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэл хийдэг болсноос хойш хүнд гэмтэх явдал алга болсон гэж үздэг. Юуны өмнө хамгаалалтаа сайн сурч байж бэртэл гэмтлээс хол байна.

Гэхдээ хоорондоо мөргөлдөх, хөмсөг задрах зэрэг гэнэтийн зүйл тохиолддог. Энэ бол ямар ч спортод байдаг. Тиймээс ямар ч үед анхаарал болгоомжтой байж, урьдчилан сэргийлэх ёстой. [ЗГМ]

### ЗГМ ТОВЧХОН

#### » ЧӨЛӨӨТ БӨХ

Чөлөөт бөхийн клубүүдийн ДАШТ-д манай улсаас “Арслан” болон “Харгант Цамхаг”-ийн хамтарсан баг оролцохоор болсон. Манайхан тэмцээний “Б” хэсэгт Украин, Беларусийн багтай өрсөлдөхөөр болжээ. Тэмцээнд түрүүлсэн баг 25 мянган ам.долларын шагналыг авч юм.

#### » ХОККЕЙ

NHL-ийн “Флорида” багийн 44 настай довтлогч Я.Ягр тус лигт 1652 дахь тоглолтдоо оролцож, бүх цаг үеийн дөрөвт бичигддэг М.Реккитэй зэрэгцжээ. Энэ үзүүлэлтээр Г.Хой (1767), М.Мессье (1756), Р.Фрэнсис (1731) нар тэргүүлдэг.

#### » САГСАН БӨМБӨГ

Сүүлийн есөн тоглолтдоо дараалж ялаад байсан “Сан Антонио” өөрийн талбайдаа “Орландо”-д 83:95-аар дийлдэж, сайхан цуврал нь тасарлаа. “Спёрс” улирал эхэлснээс хойш бүх зочлон тоглолтдоо хожсон хэдий ч талбайдаа хийсэн найман тоглолтын дөрөвт нь дийлдээд байна.

#### » ХӨЛБӨМБӨГ

“Бавари”-гийн испани хагас хамгаалагч Хаби Алонсо багтай байгуулсан гэрээгээ сунгаж хүсэлтэйг илэрхийлжээ. Түүний одоогийн гэрээ 2017 онд дуусах юм.



# Лавлах

## сонголт Биеннальд оролцох уран бүтээлчдийг шалгаруулна

**Б.Бямба**  
ЗГМ

Венецийн дүрслэх урлагийн 57 дахь олон улсын Биенналь ирэх оны тавдугаар сарын 13-наас арваннэгдүгээр сарын 26-нд Италийн Венец хотноо болно. Энэ наадамд Монгол Улсыг төлөөлөн оролцох уран бүтээлчийг сонгон шалгаруулах гэж байна. Тус наадамд оролцох уран бүтээлчийг дараах шалгуураар сонгоно.

1. Уран бүтээлч эсвэл, баг нь контемпорари урлагийн бүтээлүүдийг мэргэжлийн өндөр түвшинд туурвиж, дотоод, гадаадын нэр хүндтэй үзэсгэлэнд оролцсон туршлагатай байна.

2. Монгол Улсын павильонд дэлгэцээр санал болгож буй бүтээл нь бэлэн, эсвэл гүйцэтгэл нь хамгийн багадаа 70 хувьтай байна.

3. Утга агуулга, зохиомж, ашигласан материал, гүйцэтгэлийн хувьд өөрийн гэсэн хэллэг, онцлох төрхтэй, давтагдашгүй шинэлэг байхаас гадна Монгол орон, дэлхий нийтэд тулгарч буй чухал асуудлуудыг хөндсөн байх нь давуу тал болно.

4. Олон улсын нэр хүндтэй уралдаан, тэмцээн, резиденс болон бусад солилцооны хөтөлбөрт шалгаран оролцож байсан нь давуу тал болно.

5. Уран бүтээлч эсхүл баг нь өөрийн куратортой байх нь давуу тал болно.

Бүтээлээ ирүүлэх эцсийн хугацаа энэ сарын 5-ны өдрийг дуустал үргэлжилнэ. Олон улсын кураторын баг Венецийн Биеннальд оролцох уран бүтээлчдийг энэ сарын 15-ны дотор сонгон шалгаруулна. [ЗГМ]

### УЛААНБААТАР ХОТ

## Газар хөдлөлтийг хэмжих 36 төхөөрөмж байрлуулжээ

Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл лхагва гарагт хуралдаж, үйл ажиллагааны чиглэл, зорилгоо хэлэлцэв.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хот орчимд газар хөдлөлт идэвхжиж байгаа бөгөөд гурван жилийн хугацаанд 2500 давтамж бүртгэгджээ. Нийслэлийн Дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч П.Баярхүү нийслэлийн хэмжээнд газар хөдлөлтийг хэмжих, эрсдлийг тодорхойлох 36 төхөөрөмж байрлуулсныг хэллээ. [ЗГМ]

### ЭРҮҮЛ МЭНД

## Үнэрлэх мэдрэмж муудах нь зөнөхийн эхлэл


АНУ-ын эрдэмтэд зөнөглөх буюу альцгеймерийн өвчнийг оношилж болох шинжийг олж тогтоожээ. Хөгшин хүний зөнөглөлтөд өртөмтгий хүн үнэр мэдрэхээ больдог байна.

Эрдэмтэд 183 хүнийг оролцуулсан судалгаа явуулаад альцгеймерийн өвчний анхан шатны шинж тэмдэгтэй хүмүүс үнэрийг мэдрч ялгахад больсныг тогтоов. Үнэртэх эрхтэн нь мэдрэлийн өвчний хөгжилтэй холбоотой гэдэгт доктор Марк Альберс итгэлтэй байна. Хөгшин хүний үнэр мэдрэх, ялгах чадварыг тогтоох дөрвөн шатлалтай аргыг энэ өвчинд өртөх магадлал өндөртэй хүмүүс дээр туршсан шинжилгээг Annals of Neurology сэтгүүлд нийтлүүлжээ. [ЗГМ]

### ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
<b>08.00</b>	09.10 "Дөлгөөн Дон" уран сайхны киноны гуравдугаар анги	07.00 "Блумбергийн нүүрсний форум" цуврал	07.30 "Бяцхан оцон шувуу Пороро" хүүхэдэйн кино 17-20 дугаар анги	09.30 Тог тог (season-3) 38 дугаар хэсэг
<b>12.00</b>	11.40 "Өвлийн улиралд амьтад хэрхэн бэлддэг вэ?"	11.30 "Удирдагчид Лакуатай хамт" нэвтрүүлэг	11.15 "Агуу тэсрэлтийн онол" ОАК 1,2 дугаар анги	11.40 "Хар хайман гутал" хүүхэдэйн кино 76 дугаар анги
<b>14.00</b>	14.10 Энд гарц байна: "Ажлын гараа"	15.00 "Бизнесийн төв цэг" хөтөлбөр	14.05 "80 саяын уналт" асуулт, хариултын шоу нэвтрүүлэг	15.00 Өөрчлөлт (season-1) 20 дугаар хэсэг
<b>18.00</b>	17.50 Соно студи: "Маамуу нааш ир"	17.00 "Bloomberg Surveillance" шууд орчуулгын хөтөлбөр	17.00 "Нууц ажилтан КС" ОАК 24,25 дугаар анги	18.00 "Наашаа цаашаа" нэвтрүүлэг
<b>20.00</b>	19.20 Эх өв: "Дархадын содон билиг"	20.00 "Made In Mongolia: Эко гэр цэцэрлэг" нэвтрүүлэг	20.50 "Ялалт" ток шоу нэвтрүүлэг (Буудлагын спортын ОУХМ Г.Нандинзаяа)	20.00 "Оргил цаг" мэдээллийн хөтөлбөр
<b>22.00</b>	22.15 "Сабрина" уран сайхны кино	22.00 "Америк хэрхэн ажилладаг вэ" нэвтрүүлэг	22.00 "Доктор Хэн" ОАК 7 дугаар бүлэг 8 дугаар анги	22.30 "Хар жагсаалт" (season-3) ОАК 12 дугаар анги

### ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



- 14. Даавууны өргөний хэмжээ
- 15. Уахан, санамж

#### ХӨНДЛӨНГӨӨР:

- 2. Номхон далайн нэрийг өгсөн Португалын алдарт

- 8. Үндэсний хөгжим
- 9. Гэгээн ... наадам
- 11. Үндэс
- 12. Хурдан морийг бэлтгэгч
- 16. Леонардо да Винчийн алдарт зураг

#### ТАШУУГААР:

- 1. Узбек
- 5. Өндөр уулархаг газраар нутагладаг нэн ховордсон шувуу

- 6. Толгойгоо таслуулчихаад 7 хоног амьд байдаг шавьж
- 7. Лам, санваартны өмсгөл, нөмрөг
- 10. Д.Банзрагчийн алдарт роман
- 13. Номхон далайд орших Индонезийн арлууд



#### БОСООГООР:

- 3. Бууны эд анги
- 4. Италийн мөнгөн тэмдэгт



Өмнөх дугаарын хариу / 11.30

### ЦАГ АГААР




### ОНЦЛОХ ҮЗВЭР

## Дэлхийн сонгодог MOVIE SWING




Киног амьдралд хамгийн чухал зүйлсийн нэг бол хөгжим юм. Тэгвэл кино сонирхогч та бидний сэтгэл зүрхэнд хоногшсон дэлхийн болон Монголын олон сайхан киноны хөгжимүүд улсын Филармонид эгшиглэх нь. Баянмонгол жазз найрал хөгжмийн дэлхийн шилдэг киноны хөгжмийн дээжээс толилуулах MOVIE SWING тоглолт маргааш болох гэж байна. Улсын Филармонид болох энэхүү тоглолтод удирдаач С.Саруул-Од, Баянмонгол жазз найрал хөгжим, дуучин Н.Наранбаатар, дуучин Ц.Хулан, П.Өнөржаргал, Б.Солонго, "Lemons" хамтлагийн дуучин Одноо нарын уран бүтээлч оролцоно. [ЗГМ]

### ЗГМ: СҮДОКУ



(Өмнөх дугаарын хариу)



(Өмнөх дугаарын хариу)

### ҮЗВЭР

#### UDÉZT

Италийн хөгжмийн зохиолч Ж.Пуччинигийн "Тоска" дуурийг энэ сарын 3-нд тоглоно. Үзэсгэлэнтэй хэдий ч гэнэн томоогүй Тоска бүсгүйн хайр дурлалын ээдрээг уг бүтээлээр үзүүлдэг.

#### BLUE MOON

Гэрэл зураг сонирхогчид нэгдэж "Бидний өнцөг" үзэсгэлэнгээ маргааш 18.00 цагт нээх гэж байна. Энэхүү үзэсгэлэнг үнэ төлбөргүй үзэж сонирхох боломжтой. Эдгээр гэрэл зурагчдын дуранд буусан өөр өөрийн өвөрмөц өнцгийг хүлээн авч үзээрэй.

#### УЛААНБААТАР ЧУУЛГА

"Улаанбаатар цирк"-ийн жүжигчдийн тоглолт энэ сарын 3-нд болох гэж байна. Уг тоглолтод Турк, Япон, ХБНГУ, Франц зэрэг олон оронд тоглосон шилдэг үзүүлбэрүүдээ толилуула. Тоглолтыг 10 мянган төгрөгөөр үзээрэй.

#### ШАНГРИ-ЛА

Энэ сарын 2-нд анх удаа "Хагас нүцгэн урлаг" шоу-г зохион байгуулах гэж байна.

Уг шоу "Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн төлөө" уриан дор зохион байгуулах юм.

#### UB PALACE

Ковер дуучин Ануц, Очмаа нарын тоглолт энэ сарын 3-нд болно. Тэд тоглолтын орлогоо "Ид шидийн орон" хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийг барих газрыг худалдаж авахад хандивлах юм. Тоглолтын тасалбар 10 мянган төгрөгийн үнэтэй.

#### МИШЭЭЛ ЭКСПО

Шинэ жилийн баярыг угтсан "Women expo 2017" үзэсгэлэн худалдаа энэ сарын 3, 4-нд болох гэж байна. Энэ үеэр монгол дизайнеруудын гоёлын даашинзны загварын шоу үзүүлэх юм.

### ЗУРХАЙ



#### Билгийн тооллын 2

Өвлийн дунд цагаан хулгана сарын таван шар мэнгэтэй улаагчин могой өдөр

Үс засуулбал: Хэл, ам, хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шингээ: 08.20-17.08

Барилдлага: Үл зохилдох

Шүтэн барилдлага: Мунхрахуй

#### Аргын тооллын арванхоёр-дугаар сарын 1, Бархасвадь гараг. Билгийн тооллын 2. Гар одтой, улаагчин могой өдөр.

Өдрийн наран 08.20 цагт мандаж, 17.08 цагт жаргана. Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

#### ГАЛТ ТЭЭРЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20
Эрээн-УБ	18.00	11.15
УБ-Хөх хот	20.00	20.49
Хөх хот-УБ	22.50	11.15
УБ-Сүхбаатар	21.15	05.12
Сүхбаатар-УБ	20.55	05.03
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Эрдэнэт-УБ	19.10	05.48

#### НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Сөүл	09.45	12.50
Сөүл-УБ	01.20	04.50
УБ-Хонконг	07.25	10.55
Хонконг-УБ	12.05	17.45
УБ-Ханбумбат	08.25	09.35
Ханбумбат-УБ	10.25	11.40
УБ-Бээжин	18.55	20.10
Бээжин-УБ	21.10	00.40
УБ-Ханбумбат	20.00	21.10
Ханбумбат-УБ	22.00	23.15

**[ЗГМ]**

"ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ" Сонины онлайм захиалга ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

"ZGM-FINANCIAL TIMES" ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД 5000 ТӨГРӨГ

**99903581, 70103131**

УНШИГЧ ТА МАНАЙ Сонины Нийтлэл, МЭДЭЭ, СУРВАЛЖЛАГАТАЙ ХОЛБООТой САНАЛ ХҮСЭЛТЭЭ

**OPED@ZASAG.CO**

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

### ЗГМ: КОМИКС

Мр. Баагийгийн ПАЯН.....

Танай ангийн Хүдэрээ юу хийж байгаа вэ?

Тэр муу жулдрай том бизнесмэн болсон гэнэ лээ

Нөгөө Гэнэбат?

Яаманд хэлтсийн дарга ш дээ, дурак чинь

Чи минь хэзээ "жулдрай дурак" болно доо, Баагий минь

Н.Эрдэнэбаяр, Э.Тамир ©

NOMADIC COMICS



## Япон, Өмнөд Солонгост шувууны ханиад тархав

Шувууны ханиад тархаж байгаа нь Азийн эрүүл мэндийн албаныхны сэтгэлийг түгшээж эхлэв. > 10

## Бразил хөлбөмбөгчдөө алдаж, гашуудал зарлалаа

Бразилын өөдөлж яваа клубийн хөлбөмбөгчдийн сууж явсан онгоц осолдсоноос 75 хүн амь үрэгджээ. > 10

## Дүрвэгсдийг угтах “улаан хивсний” бодлого

Германы канцлер А.Меркель Европыг зорьсон дүрвэгсдэд хилээ нээснийг ёс суртахууны эр зориг хэмээн үнэлж байв. > 10



BBM©

# Эдийн засгийн өсөлт-шинэ Ерөнхийлөгчийн ирээдүй

АНУ-ын эдийн засгийн түлхүүр үзүүлэлт болох хэрэглээний өсөлт анх тооцолж байсан 2.1 бус, бүр 2.8 хувиар өслөө. Шар буурцгийн ургац, үйлдвэрлэлийн нөөц урьд байгаагүйгээр нэмэгдсэнээс шалтгаалан дотоодын нийт бүтээгдэхүүн анх тооцоолсноос илүү өссөнийг Citigroup-ийн стратегич Эндрю Холленхорст тайлбарлав. “Цаашид хэдэн улирал, ялангуяа хэрэглээ өсөх төлөвтэй” хэмээн тэрбээр өгүүлэв.

Дээрхээс гадна есдүгээр сард АНУ-ын орон сууцны үнэ 2006 оны үнийн хөөрөгдлөөс хойш үнэмлэхүй түвшинд өсөөд байна. АНУ даяар байр сууцны үнэ тогтвортой өссөөр эдийн засгийн уналтын дараах зах зээлийн үе төгсгөл болох тэрхүү цэг дээр хүрч ирлээ. Энэ есдүгээр сард орон сууцны үнэ жилийн дунджаар 5.5 хувь өссөн нь орон сууцны арилжаа ид цэцэглэж

байсан 2006 оны долдугаар сарын өсөлтөөс даваад байгааг S&P CoreLogic Case-Shiller үнийн индекс харуулав.

Орон сууцны зах зээлийн бусад үзүүлэлт сүүлийн хэдэн жилд тогтвортой сайжирсан ч энэ зууны эхэн үеийн оргил үзүүлэлтээс доогуур хэвээр. Жишээ нь, аравдугаар сарын байдлаар хуучин орон сууцны борлуулалт жилийн дунджаар 5.6 сая ширхэгт хүрсэн нь 2010 онд 3.5 сая байсан үнэмлэхүй доод үзүүлэлтээс хавьгүй өндөр. Гэхдээ энэхүү хувь хэмжээ нь 2005 онд үнэмлэхүй буюу 7.3 саяд хүрсэн үзүүлэлтэд бараадахааргүй бага.

Ноён Трамп Ерөнхийлөгч болох гэж буй үед АНУ-ын эдийн засаг сайжирч байгаа нь санхүүгийн хямралын ид үед албан тушаалаа хүлээн авсан Барак Обамагийнхаас эрс ялгарч байна. Ноён Трамп “Эдийн засгийн өсөлт, ажлын байр, айл гэрийг АНУ-ын

түүхэнд байгаагүйгээр дэмжих төлөвлөгөө”-нийхөө хүрээнд тус улсын эдийн засгийг жилд дунджаар 3.5 хувиар өсгөхөөр амласан. Тэрбумтан засгийн газрын зардлыг ихэсгэх, татвар багасгах, зохицуулалтыг сулруулах замаар эдийн засагт түлхэц өгөх төлөвлөгөө дэвшүүлж байна.

“АНУ-ын эдийн засаг арваннэгдүгээр сарын сонгуулиас өмнө тогтвортой өсөх голдрилдоо орчихоод байсан. Дональд Трамп санхүүгийн бодлогоо зөв чиглүүлж чадвал эдийн засаг бүр ч хурдацтай өснө” хэмээн Jefferies-ийн ахлах эдийн засагч Уорд МакКарти тайлбарлав. Уолл Стрийтийн эдийн засагчид арваннэгдүгээр сарын 8-ны сонгуулиас хойш эдийн засгийн урьдчилсан тооцоонд засвар оруулсан. Гэхдээ л 2017, 2018 оны өсөлтийг 2.2 хувиар тооцоолсон нь ноён Трампын дэвшүүлдгээс бага байгаа Bloomberg-ийн

судалгаа харуулав. Үүний зэрэгцээ ноён Трамп гадаад худалдаа, цагаачлалын асуудалд протекционист бодлого баримталдаг нь одоогийн эерэг хандлагад сөрөг нөлөөлж болзошгүй хэмээн эдийн засагчид анхааруулж байна.

“Гадаад худалдаа, цагаачлалд шинээр хязгаарлалт тогтоох нь дэлхийн ханган нийлүүлэх сүлжээг тасалдуулж, эцэст нь дотоодын үнэ өсөхөд хүргэнэ. Бизнесийн хөрөнгө оруулалтад ч хөнөөлтэй” хэмээн JPMorgan-ы ахлах эдийн засагч Брюс Касман өгүүлэв. Ноён Трампын бодлого АНУ-д инфляцийг хөөргөж болзошгүй нь Обамагийн засаглалаас ялгардаг. Мягмар гарагт нийтлэгдсэн дээрх тайлантай уялдан үнийн уналт төгсгөл болж, өсөлт хурдсах хэрээр тогтмол орлого бүхий зах зээлд арилжаа эрс өснө хэмээн шинжээчид таамаглаж байна.



# Бээжингийн эрх баригчдын ар гэрийнхнийг мөрдөн шалгана

Луси Хорнби

Эрх баригчид Бээжин хотын захиргаанд ажиллагсдын эхнэр, нөхөр, үр хүүхдүүдэд хамаатай авлигын хэргийг мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэхээр шийдвэрлэв. Уг арга хэмжээ нь тус хотын хариуцлагатай албан тушаалтнуудад ар гэрийнхэндээ хяналт тавьж байгаарай гэсэн сануулга болох юм.

Ирэх жилээс хэрэгжүүлж, цаашид тогтмол өрнүүлэхээр төлөвлөсөн тухай албан ёсны “Шиньхуа” агентлаг мэдээллээ. Лондон, Вашингтоны адилаар Бээжинд БНХАУ-ын Засгийн газар болоод хотын захиргаа аль аль нь байрладаг. Улсын хэмжээний авлига нь асар их мөнгө, эрх мэдэл олж авах хэрэгүүр мөн ч орон нутгийн түвшний авлига тус улсын иргэдийн өдөр тутмын амьдралд түвэг учруулагч гол бэрхшээл болдог.

Хятадын нийслэлд улсын санхүүгийн хөрөнгө цутгах

хэрээр орон нутгийн хэмжээний авлига гүнзгийрч байна. Бээжинд үл хөдлөх хөрөнгийн үнэ тэнгэрт хадсан нь төрийн зарим ажилтнуудад хөрөнгө хуримтлуулах сайхан нөхцөл бүрдүүлж өглөө.

БНХАУ-ын дарга Ши Жиньпин хүчирхэг “бар”-ыг ч, доод албаны “батгана”-ыг ч ялгаварлалгүй шийтгэж буй авлигатай тэмцэх кампани дөрөв дэх жилдээ үргэлжилж байна. Гэхдээ л Хятад улсад төрийн ажилтнууд, тэдний ар гэрийнхний хөрөнгийг олон нийтэд ил тод зарладаггүй хэвээр. Өнгөрсөн сард хуралдсан ХКН-ын бүгд хурлын дараа гадаадын сэтгүүлчдэд хийсэн мэдэгдлээс үзвэл тус улс ойрын үед “Наран гэрэлтүүлэх хууль” гаргахгүй бололтой.

Тохирох хууль зүйн орчин бүрдээгүй, хэрэгжүүлэгч найдвартай байгууллага байхгүй учраас авлигатай тэмцэх кампани өгөөж муутай хэмээн

зарим нь Хятадын засгийн газрын стратегийг шүүмжилдэг. Авлигатай тэмцэх арга хэмжээ, гадаадад зугтаж гарсан албан тушаалтнуудыг буцаан авчрах ажил нь эрх мэдлийг буруугаар ашиглах явдлаас сэргийлэн хүчний харьцааг тэнцвэржүүлэх, хяналт шалгалтыг сайжруулах ажилтай хослох ёстойг санхүүгийн Caixin сэтгүүлийн ерөнхий эрхлэгч Ху Шули анхааруулав.

Даваа гарагт “Шиньхуа” агентлагаас гаргасан уг мэдээлэл нь Хятадын зарим том хотын албан тушаалтнуудын ар гэрийнхний мэдэлд байдаг, нийт улсыг хамарсан бизнесийн сүлжээг шалгах санаачилгатай холбоотой.

Намаас буруутайг нь тогтоогоогүй нөхцөлд сайд зэрэг улсын түвшний албан тушаалтнуудтай холбоотой авлигын хэргийг мэдээлэхээс Хятадын мэдээллийн хэрэгслүүд зайлсхийдэг. Дөрвөн жил

үргэлжилж буй авлигатай тэмцэх кампанийн явцад хууль бус хөрөнгө ихэвчлэн эрх баригчдын хамаатан садны нэр дээр байдаг нь тодорхой болсон юм. Мөн авлигач албан тушаалтнууд зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг хувийн бизнес эрхлэгчтэй тохиролцож, нэгдэл, холбоо байгуулах замаар бие биенийнхээ эрх ашигт үйлчилдэг байна.

Харин Хятадын нийслэлд амьдардаг гадаадынхан тус улсын хүнд сурталтнуудын ашиг хайсан харьцаа, хятад иргэдийг нухчин дарагч цагдаагийн халдлагаас ихэвчлэн ангид. Гэхдээ Бээжингийн тансаг зэрэглэлийн хороололд амьдардаг зарим гадаадын иргэн Хятадын цэргийнхний ар гэрийнхний мэдэлд ажилладаг авлигач компаниудын менежментээс болж шүүхээр заргалдахад хүрсэн жишээ сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна.



Ноён Трамп НАТО-гийн гишүүн Европын улсуудад батлан хамгаалах зардлаа дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ хоёр хувь хүртэл өсгөхийг байнга шаардаж ирлээ. Европын холбооны 28 улсаас 22 нь НАТО-гийн гишүүн. Гэтэл эдгээр улсаас Их Британи, Эстон, Польш, Грек л уг шаардлагад нийцдэг.

Тус комиссын дэд ерөнхийлөгч Юрки Катайнен дэвшүүлсэн, Европын холбооны батлан хамгаалах төлөвлөгөөгөөр тус тивийн агаар, газар, сансрын батлан хамгаалах чадварыг сайжруулж, кибер аюулгүй байдал, тагнуулын мэдээ цуглуулах ажилд хөрөнгө оруулна.

Европ тивд олон улсын терроризм гаарч, ОХУ Украинаас Крымыг булаан авч, дорнод Украины саан тусгаарлагчдыг өөгшүүлэн дэмжих нь идэвхжсэн нөхцөлд

жүүлэх зорилгоор Европын батлан хамгаалах бонд гаргаж болох талаар ноён Катайнен есдүгээр сард Financial Times-д тайлбарласан.

Европ нь цэргийн зардлын хэмжээгээр дэлхийд хоёрдугаарт ордог ч зэвсэг техник, технологийн зөрүүнээс шалтгаалан хамтын ажиллагаа үр ашиг муутай байдгийг тус комиссын төлөвлөгөөнд анхааруулжээ. Батлан хамгаалах салбарт гишүүн улс хоорондын хамтын ажиллагаа уялдаа муутай, өрсөлдөөнгүй, эдийн засгийн цар хүрээ хумигдмал байдаг дутагдал нь Европын холбоонд жил бүр 25-100 тэрбум еврогийн нэмэлт зардал үүсгэдэг талаар тус комисс тайлбарласан юм. Харин АНУ цэргийн зардалдаа Европын холбооноос хоёр дахин их хөрөнгө зарцуулдаг.





© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.



## Япон, Өмнөд Солонгост шувууны ханиад тархав

**Робин Хардинг, Брайан Харрис**

Шувууны ханиад тархаж байгаа нь Азийн эрүүл мэндийн албаныхны сэтгэлийг түгшээж, 2000 оноос хойш 450 гаруй хүний аминд хүрсэн H5N1 вирусийн гунигт дурсамжийг сэдэрэв. Японы Нийгата, Аомори мужид H5 вирусээр шувуу үхсэний дараа 300 мянга орчим тахиа, нугасыг устгажээ. Дараахан нь Өмнөд Солонгост 1.5 сая орчим шувууг устгав. Үүний улмаас тахиа, нугасын аж ахуйнуудад үүссэн шувууны ханиадны шинэ төрөл Азийн хөгжил буурай газруудад тархсанаар хүнд халдварлах вий гэсэн болгоомжлол үүсээд байна.

Японы танхимын нарийн бичгийн дарга Иохихиде Суга “Ханиад үүссэн нөхцөл байдлыг шалгахын сацуу, вирус тархсан фермүүдийн ойр орчмыг халдваргүйжүүлэх арга хэмжээ авч, гол замууд дээр ариутгах цэг ажиллуулж байгаа” хэмээв. Японы эрэг хавийн бүсэд 2015 оны нэгдүгээр сард зэрлэг шувууд үхсэнийг шинжилж, анх уг өвчнийг илрүүлсэн юм. Токиогийн шинжээчид H5 вирусийн дэд төрөл болохыг тэр дор нь тодорхойлж чадаагүй аж.

2014 онд Хятадад дэлгэрсэн шувууны ханиадны дэд төрөл болох H5N6 хэмээх үхлийн аюултай вирус Өмнөд Солонгост мөн тархаж, түгшүүр зарлаад байна. Энэ нь хүнд халдварлах магадлалтай агаад наад зах нь есөн хүний аминд хүрсэн юм. Тус улсын Хөдөө аж ахуйн яам ямар гаргагч Жиеонжи, Өмнөд Жеолла мужид халдварын 41 голomt илэрснийг нотлов. Өнгөрсөн амралтын өдрүүдэд шувуун фермүүдийн үйл ажиллагаа болон тээвэрлэлтийг зогсоох тушаал гаргасан хэдий

ч вирусийн тархалт нэмэгдсээр байгаа аж.

Өмнөд Солонгосын албаныхан 1.7 сая шахам тахиа, нугас нядлах шийдвэр гаргаж, хэрэгжүүлсэн ч нүүдлийн шувуудаар өвчин тархаж буйг мэдээлэв. ХААЯ-ны мэдэгдэлд “Өвчний тархалт маш түргэн байгаа тул удалгүй баруун бүсэд хүрч, нийт нутгийн хамрах аюултай. Иймээс мужийн захиргаад түргэн тусламжийн төвүүд нээж, ариутгах, халдваргүйжүүлэх арга хэмжээг чангатгах ёстой” гэсэн үүрэг өгчээ.

Уг ханиадны вирус гадаргуу дээрх хоёр протейнээс хамааран дэд төрлүүдэд хуваагддаг. Үүнд hemagglutinin (H) нь 18 дэд төрөл, neuraminidase (N) нь 11 дэд төрөлтэй байдаг аж. H1N1, H3N2 хэмээх хоёр дэд төрөл нь хүнд халдварлах чадвартай. Энэхүү хоёр дэд төрөл дотор ч бас өөр зүйлийн вирус илрэх болжээ. Түүнчлэн Европт H5 вирусээр үүссэн шувууны ханиадтай тэмцэх үүднээс Герман, Голланд, Швейцарь улс олон тооны тахиа шувуу устгах арга хэмжээ авсан. Мөн Энэтхэгийн Дели хотод энэ жил шувууны ханиад илэрсэн тул амьтны хурээлэнгээ хахад хүрч байв.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага шувууны ханиадны шинэ илэрц мэдэгдэж байгаа боловч хүнээс хүнд халдварлах магадлал багатай хэмээн аюул заналыг онц ноцтой гэж үзэхгүй байна. Гэхдээ шувууны ханиад хүнээс хүнд дамжиж түргэн тархвал нийтийг хамарсан халдвар үүсгэх магадлал бий. Одоогоор H5N1 вирусийн хувьд тийм зүйл болоогүй байна.



## Бразил хөлбөмбөгчдөө алдаж, гашуудал зарлалаа



BBM©

**Жозе Лихи, Андрес Шипани**

Бразилын өөдөлж яваа клубийн хөлбөмбөгчдийн сууж явсан онгоц Колумбын Меделлин хот орчимд осолдсоноос 75 хүн амь үрэгдлээ. Тус улсад мягмар гарагаас эхлэн гурав хоногийн гашуудал зарлав. Бразилын Хөлбөмбөгийн холбоо энэ долоо хоногийн бүх тэмцээнээ хойшлуулсны зэрэгцээ хэрүүл тэмцэлтэй байгаа улстөрчид маргаанаа хойш тавин амь үрэгдэгдийн гэр бүлд эмгэнэл илэрхийлж байна.

Өмнөд Америк тивийн цомын шувтаргын тэмцээнд оролцохоор Өмнөд Катарина мужийн Шапеко хэмээх жижиг хотын “Шапеконсе” клубийн тамирчид болон багийн ажилтан, сэтгүүлчид явж байв. Уг онгоц Меделлин хотын онгоцны буудалд буухаар бэлтгэж байх үедээ осолджээ. Нийт 72 зорчигч, нислэгийн багийн есөн хүнээс ердөө зургаа нь амьд үлдсэн

байна. “Шапеконсе” багийн хамгаалагч Алан Рушел амьд үлдсэнийг албаныхан нотлов.

Энэхүү эмгэнэлт явдал Латин Америкийн хамгийн том улсад улс төр, эдийн засгийн давхар хямрал нүүрлээд буй үед сэтгэл санааны хүнд цохилт боллоо. Бразилын Ерөнхийлөгч Дилма Руссеффт үл итгэх асуудлаар санал хурааж түүнийг огцруулсны зэрэгцээ эдийн засаг уруудах хандлагатай байгаа. Тус улсын одоогийн Ерөнхийлөгч Темер “Маш гунигтай мэдээ ирлээ. Өнгөрөгсдийн хойноос залбирахаас гадна бидний хийж чадах ганц зүйл бол тэдний гэр бүлд холбооны Засгийн газраас бүх талын дэмжлэг, тусламж үзүүлэх явдал” гэжээ.

Сөрөг Ажилчны намын дарга, Ерөнхийлөгч асан Лула ад Силва бразилчуудад эмгэнэл тохиосон энэ гунигтай цаг үед “Шапеконсе” багийг дэмжиж, нэгдэхийг уриалав. Колумбын

Ерөнхийлөгч Хуан Мануэл Сантос уг сүйрлийг “Биднийг гашуудалд автахад хүргэсэн эмгэнэл” хэмээн нэрлэсэн байна. Европт Бразилын хөлбөмбөгчин Неймарын тоглодог “Барселона” баг бэлтгэл эхлэхийн өмнө нэг минут дуугаа хурааж эмгэнэл илэрхийлжээ.

Аврах ажиллагаа цаг агаарын байдал, үзэгдэх орчин муугаас саатаж, онгоц унасан Серро Гордо хотын орчимд зөвхөн машинаар очихоос аргагүй аж. Даваа гарагт орон нутгийн цагаар 10 цагийн орчимд онгоцонд шахилгааны гэмтэл гарсан учир түгшүүр зарласан гэж нислэгийн албанаас мэдээллээ. Гэвч Колумбын иргэний агаарын тээврийн газар түлш дууссан байж болзошгүйг үгүйсгээгүй байна.

“Шапеконсе” багийн төлөөлөгч фэйсбүүктээ байдал тодорхой болтол тайлбар өгөхгүй гээд “Манай тамирчид, ажилтан, сэтгүүлчид, тэдэнтэй хамт явсан

зочид төлөөлөгчдийг бурхан ивээг” гэж бичсэн байна. Тус багийн удирдлага мөрөөдөлдөө ойртож ирсэн үед ийм эмгэнэл тохиолдлоо хэмээн уйлж буй дүрс телевизээр гарсан юм. Сан Паулу, Рио де Жанейро зэрэг том хотын клубүүд ноёрхдог Бразилын хөлбөмбөгийн нэгдүгээр лигт “Шапеконсе” баг 1970-аад оноос хойш анх удаа 2014 онд гарч ирсэн билээ.

Тус баг өнгөрсөн долоо хоногт Аргентиний “Сан Лоренцо” багийг хожиж, Латин Америк тивийн цомын тэмцээний шигшээ тоглолтод хүчээ сорих эрх авсан юм. “Шапеконсе” клубийн дэд ерөнхийлөгч Айвэн Тоццо спортын телевизээр хэлсэн үгэндээ “Манай хотод олон хүн уйлан гашуудаж байна. Бид ийм юм болохыг төсөөлөө ч үгүй. “Шапеконсе” бол эндхийн баяр хөөрийн хамгийн том эх булаг байсан юм” хэмээн өгүүлжээ.



## Дүрвэгсдийг угтах “улаан хивс”-ний бодлого

**Гай Чазан**

Голам Хосейн Резаяи бол Герман улс дүрвэгсдийг нутагтаа хэрхэн суурьшуулж байгааг сурталчлах амьд үлгэр жишээ юм. Гурван хүүхдийн эцэг, афган гаралтай цагаач энэ хүн саяхан Германы телевизийн дүрвэгсдийн тухай нэвтрүүлэгт оролцож, яаж ажил, амьдралтай болж буй талаараа ярьсан юм. Тэрбээр сүүлийн дөрвөн сар Берлинээс зүүн хойно байрлах Нойруппин хотын Orpitz Holz-bau хэмээх барилгын компанид ажиллажээ. Гэтэл есдүгээр сард түүний орогнол авах хүсэлтэд татгалзсан хариу өгсөн аж. Тиймээс ноён Резаяи болон эхнэр Можган, гурван хүүхдэд нь албадан гаргах эрсдэл тулгараад байна. 32 настай цагаач эр “Би үнэхээр айж байна. Афганистанд нөхцөл байдал маш аюултай байгаа” гэв.

Германы канцлер Ангела Меркель өнгөрсөн жил Европыг зорьсон дүрвэгсдэд хилээ нээх шийдвэр гаргасныг ёс суртахууны томоохон эр зориг хэмээн үнэлж байв. Энэ нь тэдэнд аюулгүй байдал, шинээр эхлэх найдвар төрүүлсэн билээ. Гэвч хошигний цаана Германы найрсаар угтах бодлогыг ихээхэн засварлажээ. Улаан хивс дэлгэж байсан Засгийн газар одоо төрөл бүрийн саад тээг тавих боллоо. Ийнхүү ноён Резаяийн хувь заяа шинэ хатуу бодлогын бэлгэдэл болон хувирчээ.

Бодлогын ийм өөрчлөлт нь



BBM©

зарим талаар Германы альтернатив намтай холбоотой. Хэт барууны чиглэлийн тус нам өнгөрсөн зун Бавари мужид цагаачдын үйлдсэн алан хядах ажиллагааны дараа дүрвэгсдийн урсгалыг зогсоож, аюулгүйн арга хэмжээг чангатгахыг уриалж эхэлсэн юм. Афганчууд уг бодлогод хамгийн их хэлмэгдсэн бүлэг болж байна. Өнгөрсөн онд тэдний 77.6 хувьд нь цагаачлалын эрх олгож байсан бол энэ жил 52.4 хувь болж буурлаа.

Афганы 12539 дүрвэгчийг Германаас гарч явахыг шаардсан нь энд амьдарч буй 247 мянган афган гаралтай иргэдтэй харьцуулахад бага тоо. Энэ оны нэгтээс есдүгээр сарын хооронд 27

орогнол хүсэгчийг Афганистан руу буцаажээ. Харин өнгөрсөн онд энэ тоо ес байсан юм. Афганистанд хүчирхийлэл үргэлжилсээр байгаа үед дээрх алхам багаар бодоход зөрчилтэй гэж үзэж болохоор. Өнгөрсөн жил тэнд 3545 энгийн иргэн алагдсан бөгөөд энэ жил ч хурцадмал байдал үргэлжилсээр байгаа. Зүүний намын төлөөлөгч Улла Желпке “Афганчуудыг буцаана гэдэг нь иргэний дайнд нэрвэгдсэн орон руу хүмүүсийг илгээнэ гэсэн үг. Үхлийн аюул маш ойрхон” гэжээ.

Түүнчлэн Сирийн дүрвэгсдэд хүртэл орогнол олгох нь баталгаатай бус. 1951 оны Женевийн конвенцийн хүрээнд тэдэнд бараг

бүгдэд нь орогнох эрх өгч байв. Харин одоо “нэмэлт хамгаалалт” хэмээх заалтын дагуу нэг жил оршин суух боловч гэр бүлийн гишүүдээ Германд авч ирэх эрхгүй болжээ. Холбооны статистикийн мэдээгээр аравдугаар сард Цагаачлалын алба орогнол хүсэгчдийн 35 хувь нь “нэмэлт хамгаалалт”-д хамрагдсан нь цагаачлалын эрх авсан 26 хувиас давсан үзүүлэлт боллоо. Тэднээс 23 хувьд нь шууд татгалзсан хариу өгсөн байна.

Дүрвэгсдийг дэмжигч Про-Asyl бүлгийн төлөөлөгч Гюнтер Буркхардт “Орогнол олгох хувь хэмжээ эрс доошилсон. Гэтэл цагаачдын гарч ирсэн

улсад нь байдал өөрчлөгдөөгүй байгаа” гэж ярьсан юм. Про-Asyl бүлэг Засгийн газар афганчуудад орогнол олгохыг багасгах даалгавар өгсөн хэмээн шүүмжилснийг Цагаачлалын алба няцаав. Шинжээчдийн үзсэнээр хууль чангарч байгаа хэдий ч Германы тал Европт дүрвэгсдэд хамгийн найрсаг ханддаг орон хэвээр байгаа аж.

Өнгөрсөн жил Европт орогнол хүссэн нийт 1.26 сая дүрвэгчийн 441800 буюу 35 хувь нь Германд бүртгэгджээ. Түүнчлэн эхлээд татгалзсан хариу авсан дүрвэгч шүүхэд хандах эрхтэй. Энэ оны нэгтээс аравдугаар сард “нэмэлт хамгаалалт” авсан 113500 дүрвэгчийн 32500 нь шүүхэд гомдол мэдүүлсний олонх нь сиричүүд байна. Шүүхээр хэлэлцсэний дараа гомдол гаргагчдын 76 хувь нь заргаа авч, цагаачлалын бүрэн эрх авсныг Цагаачлалын албанаас мэдээлэв.

Ноён Резаяи 2014 онд Афганистаны баруун нутгийн Херат хот дахь орон гэрээ орхин гарчээ. Өмнө нь автобусанд сууж яваад Талибаны босогчдын халдлагад өртөж, хөлдөө сумны шарх авсан аж. Зэвсэгт бүлэглэл түүний хүүг хулгайлж, барьцааны мөнгө өгсөөр атал зүүн гарыг нь тайрсан гэдэг. Резаяи Иранд найман сар оршин суугаад улмаар Туркээр дамжин Балканд хүрч, тэндээсээ Германд иржээ. 2015 оны арваннэгдүгээр сард энд ирснээсээ хойш хоёр сарын дараа орогнол авах

хүсэлтээ илгээсэн байна.

Бидэнд үзүүлсэн 2016 оны есдүгээр сарын 15 гэсэн огноотой албан бичгээр Цагаачлалын алба түүнд орогнол олгохоос татгалзаж буйгаа мэдэгдсэн байв. Энд бичсэнээр ноён Резаяи болон түүний гэр бүлд үндэс угаа, шашин шүтлэг буюу улс төрийн итгэл үнэмшилд суурилсан хүчирхийлэлд өртөх “үндэслэлтэй айдас” тулгараагүй учир татгалзав хэмээн тайлбарлажээ. Түүнчлэн тус алба Афганистанд хүчирхийллийн золиос болох магадлал 0.074 хувьтай байгаа нь эрсдэл маш бага гэдгийг харуулж байна гээд түүний төрөлх хотыг харьцангуй тайван хэмээн үнэлсэн аж.

Цааш нь ноён Резаяи эрүүл хүн агаад мужааны ажил эрхлэн гэр бүлээ тэжээх чадвартай гэжээ. Түүнийг өөрийн орон байшинтай, шаардлагатай бол эх орондоо хамаатан саднаасаа дэмжлэг авах боломжтой гэж үзсэн байна. Резаяи шүүхэд гомдол гаргасан бөгөөд одоохондоо компанидаа үлдэх төлөвлөгөөтэй байгаа гээд “Хэрвээ намайг ажлаа алдахгүй үлдэх төлөвлөгөөтэй байгаагүй байх гэж найдаж байна” хэмээсэн юм. Түүний босс Мартин Опниц ярихдаа афган эрийн хувьд байдал сайнаар эргэнэ гэж найдаж буйгаа илэрхийлээд “Бидэнд ажилчид хэрэгтэй. Манай хүн ам улам цөөрсөөр байгаа. Миний хувьд тэр үлдэхэд болохгүй зүйл алга” гэлээ.





## Эдийн засаг

## Худалдаа сэргэх сар айсуу

**Худалдааны салбар эдийн засгийн уналтын зүтгүүр болж байна**

Г.Байгал  
@baigalZGM

Хар баасан гарагт АНУ-ын цахим худалдаа бүх цаг үеийн дээд цэгт хүрчээ. Зөвхөн цахим худалдаагаар гурван тэрбум ам.долларын борлуулалт хийснийг тус улсын Үндэсний жижиглэн худалдааны холбооноос мэдээлэв. Энэ үеэр нэг америк хүн дунджаар 289 ам.долларын худалдаа хийсэн байна. Ингэснээр тус улсын худалдаа идэвхжиж, үйлдвэрлэл эрчимжжээ. Бараан баасан гараг Америкийн эдийн засагт цагаан гэгээ татуулсан нь энэ.

Шинжээчдийн тооцоогоор хар баасангаас Зул сар хүртэлх хэд хоногийн хугацаанд тус улсын жижиглэн худалдааны 30 хувь нь борлогддог байна. Тиймээс баярын өдрүүд нь Америкийн бизнес идэвхждэг оргил үе. Учир нь тус улсын эдийн засгийн 70 хувийг иргэдийнх нь эрэлт бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл, худалдаа, үйлчилгээний салбар нь дэлхийн тэргүүлэх эдийн засгийн тулгуур болдог.

Харин манайд эсрэгээрээ. Эдийн засгийн уналтын зүтгүүр болж байна. Худалдааны салбар хумигдсан нь Монголын эдийн засаг агшихад хамгийн хүчтэй нөлөөлснийг Үндэсний статистикийн хорооноос мэдээлэв. Энэ оны эхний сарын сарын байдлаар худалдааны салбарын борлуулалт 865 тэрбум төгрөгөөр татарчээ. Үүнээс үзэхэд худалдааны уналт бараг нэг их наяд төгрөг рүү дөхсөн байх юм.

Тоон үзүүлэлт бодит байдалтай ч нийцнэ. Худалдаа хумигдсан гэдэгтэй уншигч та санал нийлэх байх. Сүүлийн 1-2 жилд борлуулалт буурсныг худалдаачид хэлдэг. Бидний нэрлэж заншсанаар “Хороолол”, д хоосон лангуу олширч, их дэлгүүрүүд эл хуль болсон нь



Б.Ганбаяр / ЗГМ ©

үнэн. Худалдааны чиглэлийн зарим аж ахуйн нэгж хаалгаа барьж буй тухай мэдээлэл хэвийн үзэгдэл мэт болсон. Зөвхөн жижиглэн биш, бөөний борлуулалт ч үлэмж хэмжээгээр багасчээ. Статистик мэдээллээр жижиглэн худалдаа 742.3, бөөнийх 123 тэрбум төгрөгөөр буурсан байх юм.

Борлуулалт буурч, орлого багассан. Дайран дээр давс гэгчээр үнэ унасан. Сүүлийн хоёр сар дараалан Монголын эдийн засагт дефляци нүүрлээ. Зэрэгцсэн эдгээр уналт нь худалдаа эрхлэх боломжийг хумьж байна. Ашиг олохыг мартгаж, тэсэж үлдэхээр л чармайж буйгаа танил худалдаачин маань ярилаа. Санхүүгийн байдал нь тамирдаж, ажлын байраа танахаас өөр сонголт түүнд үлдээгүй аж.

Бид ашигт малтмалаа экспортлоод, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн импортлодог. Түүхий эдийн хавсарга төдий орон. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийхээ талаас илүүг импортоор авдаг. Энэ оны эхний

10 сарын байдлаар хилийн чанадаас авсан худалдаа өмнө оны мөн үеэс 12 хувиар буурчээ. 395.3 сая ам.доллар буюу 800 гаруй тэрбум төгрөгөөр багассан гэсэн үг. Энэ үзүүлэлт 2015 онд ч буурч байв. Өнгөрсөн онд 3.7 тэрбум ам.долларын худалдан авалт хийсэн нь импорт түүхэнд дээд цэгтээ хүрч байсан 2012 онтой харьцуулахад хоёр дахин буурсан үзүүлэлт. Энэ хэрээр импортын татвар буурч, төсвийн “цоорхой” тэлсэн түүх бий.

Сүүлийн 20 гаруй жилийн турш Монгол Улс “худалдаачин” хэмээх нэрийг нэр төртэй зүүж байгаа. Тиймээс эдийн засагт арилжааны гүйцэтгэх үүрэг жинтэй. Худалдааны салбарын жилийн борлуулалт 8.2 их наяд төгрөгтэй тэнцдэг. Нийт 26.5 мянган аж ахуйн нэгж энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй. Энэ нь үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжийн бараг 40 хувьтай тэнцэх дүн. Тэрчлэн худалдаатай хослон хөгждөг бусад салбарыг нэмж тооцвол хэр хэмжээ нь улам тэлнэ. Арилжаа, наймааг дагаж

тэвэр, түрээс гээд олон салбар хөгждөг. Өдгөө эдгээр салбарын нөхцөл байдал хүнд байна.

Шалтгаан нь түүхий эдийн үнэ унаж, орлого буурснаас төр ч, иргэд ч тэр хэмнэлтийн горимд шилжсэн. Зарцуулалтаа танасан нь худалдааны салбарыг өнөөгийн нөхцөл байдалд хүргээд буй.

Худалдааны салбар одоогоор идэвхгүй хэвээр байна. Уг нь уул уурхай, үйлдвэрлэл зогсдог өвлийн цагт арилжаа, наймаа

эдийн засгийг “гэсгээдэг”. Гэвч борлуулалт сул байгааг худалдаачид учирлаж байна.

Гэхдээ худалдааг тэтгэдэг баярын сарууд айсуу. Сар гаруйн дараа болох шинэ жил худалдаа, үйлчилгээг идэвхжүүлдэг. Жил тойрон зүгээр суусан үсчин, гоо сайханчид энэ баярыг тэсэн ядан хүлээж буйгаа хэлж байсан. Бас оргилуун дарс, амттан, бэлэг сэлт, даашинз гэсээр худалдааны салбарыг чамгүй дэмжинэ. Мэдээж, Цагаан сар бол худалдаачдын хүсэн хүлээдэг үе. Цагаан сар нь хар баасан гараг шиг жижиглэн худалдааг дэмждэг. Эдийн засагчдын тооцоогоор монголчууд цагаан сарын үеэр дунджаар 800 орчим тэрбум төгрөгийн борлуулалт хийдэг байна. Зөвхөн энэ үед хэрэглэх мах, махан бүтээгдэхүүнд 50 гаруй тэрбум төгрөг зарцуулагдсан тооцоо гарчээ. Тиймээс “хөлдсөн” худалдааг “гэсгээх” баярын сарууд айсуу. Ингэснээр эдийн засаг дахь мөнгөн урсгалын хэмжээ нэмэгдэж, бизнесийн идэвхжил сэргэх боломжтой. [ЗГМ]

» Монголчууд Цагаан сарын үеэр дунджаар 800 орчим тэрбум төгрөгийн худалдаа хийдэг.

» Эдийн засаг дахь мөнгөн урсгалын хэмжээ нэмэгдэж, бизнесийн идэвхжил сэргэх боломжтой.

## УУЛ УУРХАЙ

## БНАСАУ-ын нүүрсний экспортод хориг тавилаа

Н.Алтан  
Шинжээч

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолын дагуу БНАСАУ-ын нүүрсний экспортод хориг тавихаар болсон байна. Энэ нь тус улсын есдүгээр сард хийсэн цөмийн туршилттай холбоотой юм. Шинэ хоригийн дагуу БНАСАУ-ын нүүрсний экспортыг жил бүр 700 сая ам.доллараар буюу 62 хувиар

бууруулах аж. Үүнээс гадна зэс, никель, мөнгө зэрэг үйлдвэрлэлийн металлын экспорт ч мөн хоригт өртөнө гэж албаны эх сурвалж мэдээлжээ. Мөн НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолын дагуу тус улсын 10 аж ахуйн нэгж болон төрийн 11 албан тушаалтныг хар жагсаалтад оруулсан байна. Үүнээс гадна бусад улс орнуудыг ч БНАСАУ-д хөлөг онгоц болон нисдэргээр тэрэг нийлүүлэхийг хоригложээ.

## УУЛ УУРХАЙ

## МЕС-ийн орлого 48 хувиар өсчээ


Хонгконгийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Mongolia Energy Corporation” есдүгээр сарын 30-нд дуусгавар болсон санхүүгийн хагас жилийн тайлангаа танилцууллаа. Тус компани энэ оны гурваас есдүгээр сарын хооронд 140 сая хонгконг долларын орлого олжээ. Энэ нь 2015 оны мөн үеэс 48 орчим хувиар өссөн дүн. Бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл нь 18.3 сая хонгконг доллар байгаа талаар санхүүгийн тайландаа дурдсан байна. Энэ нь зургаан сарын өмнөхтэй харьцуулахад тав орчим хувиар буурсан дүн боллоо. Тайлант хугацаанд “Mongolia Energy Corporation” 451.4 мянган тонн нүүрс олборлож, 198 мянган тонн нүүрс борлуулсан байна.

Үүнээс 195 мянган тонн цэвэр коксжих нүүрсийг Шиньжанд нийлүүлсэн бол 3000 тонн дулааны нүүрсийг Монголын хэрэглэгчдэд нийлүүлжээ.

Цэвэр коксжих нүүрсний дундаж ханш тонн тутамд 715.8 хонгконг доллар байгаа нь 2015 оны мөн үеэс 12 хувиар өссөн дүн. Түүнчлэн дулааны нүүрсийг тонн тутамд нь 87.4 хонгконг доллараар худалджээ. Үүний дунд нийт ашиг нь 88.7 сая хонгконг долларт хүрсэн байна. БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл өссөн. Тус улсын ДНБ өнгөрсөн үеэр 6.7 хувиар тэлсэн зэрэг нь ган болон коксжих нүүрсний зах зээл энэ оны хоёрдугаар хагаст тогтвортой байна гэсэн хүлээлтийг бий болгосныг “Mongolia Energy Corporation” дүгнэжээ.

## БАРИЛГА

## Орон сууцны борлуулалт огцом буурчээ



С.Батсайхан / ЗГМ ©

Б.Дуламхорлоо  
Шинжээч

Бага хүүтэй ипотекийн зээл олголт удаашраад байгаатай холбоотойгоор аравдугаар сард орон сууцны борлуулалт огцом буурсан тухай “Тэнхлэг зууч” компаниас мэдээллээ. Шинэ болон хуучин орон сууцны борлуулалт аравдугаар сард өмнөх сараас болон жилийн өмнөхөөс 30 гаруй хувиар буурсан байна. Аравдугаар сард нийт 672 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагджээ. Үүний 10.5 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл. Харин 24.2

тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” буюу Монголбанкнаас өмнө нь олгосон зээлийн эргэн төлөлтөөр дамжуулан олгосон зээл ажээ. Цаашид арилжааны банкуудын эх үүсвэрээс үл хамааран өмнөх зээлийн эргэн төлөлтөөр ипотекийн зээлийг хэвийн үргэлжлүүлнэ гэж Монголбанк мэдээлж байна.

Аравдугаар сарын байдлаар улсын хэмжээнд 43 мянган айлын 321 шинэ орон сууцны төсөл хэрэгжиж байсан. Үүний 28 мянган айлын орон сууц ашиглалтад орж, 78 хувь нь зарагджээ. Энэ нь өмнөх саруудаас мөн л буурсан үзүүлэлт

болж байгаа юм. Сүүлийн сард улирлын нөлөөгөөр зарим барилгын ажил зогссон, үүнээс шалтгаалан худалдан авалтын захиалгаа зогсоосон нь борлуулалтын эцсийн дүнд нөлөөлжээ. Хэдийгээр эдийн засгийн өсөлт, эрэлт бага байсан ч орон сууцны үнэ их хэмжээгээр буурахгүй байгаа аж.

“Тэнхлэг зууч” компанийн мэдээлж байгаагаар аравдугаар сард орон сууцны үнийн ерөнхий индекс анх тооцож эхэлсэн 2013 он буюу суурь үеэс 1.1 хувиар өссөн. Харин өмнөх сараас 0.16 хувиар, оны эхнээс 4.1 хувиар, жилийн өмнөхөөс 5.6 хувиар буурсан байна.

## ЗГМ ТОВЧХОН

## » ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн статистикийг ОУВС-гийн зургадугаар аргачлалаар тооцож эхэллээ.

## » ТЭЭВЭР

7.6

Хувь. Агаарын тээврээр энэ оны эхний 10 сарын байдлаар 2513.5 тонн ачаа, 572.4 мянган хүн тээжээ. Зорчигч тээвэр 7.6, ачаа 6.5 хувиар тус тус өссөн байна.

## » ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

9.8

Хувь. Монголын хөрөнгийн биржийн арваннэгдүгээр сарын 30-ны арилжаагаар “Ремикон” компанийн хувьцааны ханш 9.8 хувиар өслөө. Мөн “Хай би ойл” болон “Сүү” компанийн хувьцааны ханш 5.4-5.7 хувиар тус тус дээшилсэн байна.

## » ҮНЭТ ЦААС

551

Сая төгрөг. Засгийн газрын 3400 ширхэг үнэт цаас хоёрдогч зах зээлд арилжиж, 551 сая төгрөгийн гүйлгээ хийв.

## » ДЭЛХИЙД

0.1

Хувь. Японы үйлдвэрлэлийн гарц аравдугаар сард 0.1 хувиар өссөн байна.

6

Хувь. Германы ажилгүйдлийн түвшин арваннэгдүгээр сард зургаан хувьд хадгалагдлаа. Өнгөрсөн сард тус улсад 5000 хүн шинэ ажлын байранд оржээ.

## » ВАЛЮТ

3.5

Хувь. Bloomberg-ийн ам.долларын индекс голлох 10 валютын эсрэг 0.2 хувиар чангарлаа. Тус индекс арваннэгдүгээр сарын 24-нөөс хойш 3.5 хувиар өсөөд байгаа юм.

## » ТҮҮХИЙ ЭД

0.1

Хувь. Алтны ханш 0.1 хувиар өсөж, унци нь 1187.14 ам.долларт хүрэв. Ингэснээр шаргал металлын ханш сарын дүнгээр долоон хувиар буураад байна. Энэ нь 2013 оны зургадугаар сараас хойших хамгийн огцом уналттай сар юм.

## » ХӨДӨӨ АЖ АХУЙ

27

Хувь. Аргентин улс энэ онд өнгөрсөн жилийнхээс 27 хувиар илүү буюу 14.4 сая тонн улаан буудай хураан авсан байна. Харин Австрали өнгөрсөн оныхоос 16 хувиар их буюу 28.3 сая тонн ургац хураан авчээ.


## ВАЛЮТЫН ХАНШ

АНУ, доллар	2466.64
Евро	2620.31
Япон, иен	21.88
ОХУ, рубль	37.74
БНХАУ юань	358.22
БНСУ вон	2.11



## Эдийн засаг

### Газрын тосны ханш 6.1 хувиар өслөө



Бrent-ийн ханш сүүлийн нэг сард (ам.доллараар)

Эрчим хүчний түүхий эдийн жишиг Brent төрлийн газрын тосны ханш лхагва гарагт зургаан хувиар өслөө. ОПЕС-ийн төлөөлөгчид Вена хотод чуулж буй. Уулзалтаар газрын тосны гарцаа танах, эсэхийг хэлэлцэнэ. Ираны газрын тосны сайд ОПЕС-ийн сайд нар тохиролцоонд хүрэхэд ойрхон байгаа гэж мэдэгдлээ. Энэ мэдэгдлийн дараа газрын тосны ханш сэргэлээ. Тус түүхий эдийн

ханш дөрвөн орчим хувиар унаад байсан. Тэгвэл эргэн 6.1 хувиар чангарч, тонн нь 49.20 ам.доллартай тэнцсэн байна. Хэрэв газрын тос олборлогчид орнууд тохиролцоонд хүрч чадвал ханш 55 ам.долларт хүрнэ гэж шинжээчид таамаглаж байна. Газрын тосны зах зээлд өдгөө нийлүүлэлтийн илүүдэд үүсээд байгаа. Иймд олборлолтоо танаж, зах зээлийн тэнцвэрийг хангах шаардлага үүсээд байгаа юм. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581


#### МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	57.75	▼ -4.37%	11/30/2016
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.017	▼ -10.53%	11/30/2016
PETRO MATAD	MATD	LON	GBX	6.1	▲ +1.23%	11/30/2016
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.03	▼ -9.09%	11/30/2016
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	11/30/2016
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.6	▼ -9.77%	11/30/2016
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.61	▼ -3.76%	11/30/2016
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.325	▼ -1.52%	11/30/2016
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.19	▼ -5%	11/30/2016
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.41	▼ -2.38%	11/30/2016

#### ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1187.11	▼ -0.01%	11/30/2016
ЦАГААН АЛТ	PLA	унци	922.9	▲ +0.17%	11/30/2016
МӨНГӨ	SIA	унци	16.74	▼ -0.03%	11/30/2016
ЗЭС (COMEX)	HGA	фунт	262.15	▲ +0.44%	11/30/2016
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	72.26	▲ +0.15%	11/30/2016
WPI ТОС	CLA	баррель	48.24	▲ +6.65%	11/30/2016
БРЕНТ	COA	баррель	49.71	▲ +7.18%	11/30/2016
БЕНЗИН	XBA	144	▲ +4.57%	11/30/2016	
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.306	▼ -0.27%	11/30/2016
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	323.1	▲ +0.08%	11/30/2016
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	88.5	▼ -4.07%	11/30/2016
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.196	▲ +0.15%	11/30/2016
БУДАА	RRA	центнер	9.575	▲ +0.42%	11/30/2016
БУУДАЙ	WA	бушель	413	▲ +1.04%	11/30/2016
КАКАО	CCA	тонн	2398	▼ -0.7%	11/30/2016
КОФЕ	KCA	фунт	1.532	▲ +0.13%	11/30/2016

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



#### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
ГОВЬ ХК	GOV	10340	▲ 3.82%	11/30/2016
МАХИМПЕКС ХК	MMX	2600	◀ 0.00%	11/30/2016
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	19890	▼ -0.50%	11/30/2016
СҮҮ ХК	SUU	134.5	▲ 5.41%	11/30/2016
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	18070	▲ 0.39%	11/30/2016
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	1755	▲ 2.87%	11/30/2016
БАГАНУУР ХК	BAN	2150	◀ 0.00%	11/30/2016
БИДИСЕК ХК	BDS	1400	◀ 0.00%	11/30/2016
БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК	BNG	42000	◀ 0.00%	11/30/2016
ГАН ХИЙЦ ХК	GHC	13100	▼ -14.38%	11/30/2016
ХАЙ БИ ОЙЛ ХК	HBO	185	▲ 5.71%	11/30/2016
ХӨХ ГАН ХК	HGN	59.9	▼ -0.17%	11/30/2016
ГЕРМС ХК	HRM	140	◀ 0.00%	11/30/2016
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	MDR	449	◀ 0.00%	11/30/2016

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

#### ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5379.918	+11.11	▲ +0.21%	11/30/2016
DAX INDEX	DAX	10642.55	+22.06	▲ +0.21%	11/30/2016
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	14999.81	-15.55	▼ -0.1%	11/30/2016
S&P/ASX 200	AS51	5440.473	-17.03	▼ -0.31%	11/30/2016
S&P 500	INX	2204.66	+2.94	▲ +0.13%	11/30/2016
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3250.035	-32.89	▼ -1%	11/30/2016
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	19121.6	+23.7	▲ +0.12%	11/30/2016
TOP 20	MSETOP	11093.11	+90.57	▲ +0.82%	11/30/2016
FTSE 100	UKX	6813.21	+41.21	▲ +0.61%	11/30/2016
HANG SENG	HSI	22789.77	+52.7	▲ +0.23%	11/30/2016
NIKKEI 225	NKY	18308.48	+1.44	▲ +0.01%	11/30/2016

# АМЕРИК ХЭРХЭН АЖИЛДАГ ВЭ?

Bloomberg TV MONGOLIA

"Америк хэрхэн ажилладаг вэ" цуврал нэвтрүүлгээр Америк гэх их гүрний цөмд аваачиж, энэ орныг хөдөлгөдөг нүдэнд ил харагддаггүй ажиллагаануудын нууцыг нээдэг. Харин нэвтрүүлгийн энэ удаагийн дугаарт Америк орны эрчим хүчний аварга том машин улсынхаа хэрэглээг хэрхэн хангаж, амьдрах эх үүсвэрээр тэтгэж байдаг талаар хүргэх болно. Түүнчлэн эрчим хүч хаанаас үүсэлтэй, хэрхэн ашиглагддаг, үүнийг хэрхэн үргүй зарцуулдаг, айл өрх, албан байр бүрт хэрхэн нийлүүлдэг талаар хүлээн авч үзээрэй.

Пүрэв гараг /2016.12.01/

# 22:00

07:00/14:00 Баасан гараг /давталт/

11:00 Бямба гараг /давталт/

20:00 Ням гараг /давталт/